



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

№ 23.06.08 № 35-1/94
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Д.ОЮУН-ЭРДЭНЭ

000234002598



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023 06.08 № ХЭТ/1365
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН


000235015362

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлд:

"I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.05.31 № 1 / 3103
танай _____ -ны № 01/3871 -т

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023/05/31 № 01/3872
танай _____-ны № _____-т

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,


Б.ЖАВХЛАН

9762002411



МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2023. 05. 31 № 01/954
танай _____-ны № _____-т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН ТАНАА

Танаас ирүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн
тодотголын төсөлтэй танилцлаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын
төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн
бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн
чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн
тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын
тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтын
дагуу зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Ч.ХҮРЭЛБААТАР

230531

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН
ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2024-2025
ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 он

**БАТЛАВ
САНГИЙН САЙД**

Б.ЖАВХЛАН

**БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц байхаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг байхаар, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Олон улсын валютын сангийн тооцооллоор дэлхийн эдийн засаг 2023 онд 2.8 хувиар, 2024 онд 3.0 хувиар өсөж, ирэх 5 жилийн өсөлт 3 орчим хувь буюу сүүлийн 20 жилийн дундаж болох 3.8 хувиас бага байх төлөвтэй байна.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд

байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны эхний 4 сард экспортолсон нүүрсний нийт хэмжээ өнгөрсөн оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцсэн нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг 6.0 хувьд хүргэж, цаашид эдийн засгийн үзүүлэлтэд эергээр нөлөөлөхөөр байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд байгаа тул Засгийн газраас инфляцын сөрөг нөлөөллийг бууруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан нөхцөл байдлуудаас шалтгаалан Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг зөв тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал бодитой болох юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.



ТАНИЛЦУУЛГА

*Монгол улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн
хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг анх баталж, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар уг хуульд өөрчлөлт оруулсан. Одоогийн хүчин төгөлдөр хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 19,049.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.9 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 20,475.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.6 хувь, нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 5,359.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 9.8 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1,425.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.6 хувийн алдагдалтай байхаар заасан.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Олон улсын валютын сангийн тооцооллоор дэлхийн эдийн засаг 2023 онд 2.8 хувиар, 2024 онд 3.0 хувиар өсөж, ирэх 5 жилийн өсөлт 3 орчим хувь буюу сүүлийн 20 жилийн дундаж болох 3.8 хувиас бага байх төлөвтэй байна.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны эхний 4 сард экспортолсон нүүрсний нийт хэмжээ өнгөрсөн оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцсэн нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг 6.0 хувьд хүргэж, цаашид эдийн засгийн үзүүлэлтэд эергээр нөлөөлөхөөр байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд байгаа тул Засгийн газраас инфляцын сөрөг нөлөөллийг бууруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан нөхцөл байдлуудаас шалтгаалан Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл тус бүрээр:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дугаар зүйл – Дээр дурдсан шаардлагад үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн шинэчилсэн үзүүлэлтийг хүснэгтээр тусгасан.

2 ДУГААР ЗҮЙЛ – Энэ хуулийг батлагдсан өдрөөс хойш дагаж мөрдөнө.

Хуулийг мөрдөж эхлэх огноог тусгасан.

--- оОо ---



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Монгол улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн
хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байна. Олон улсын валютын сангийн тооцооллоор дэлхийн эдийн засаг 2023 онд 2.8 хувиар, 2024 онд 3.0 хувиар өсөж, ирэх 5 жилийн өсөлт 3 орчим хувь буюу сүүлийн 20 жилийн дундаж болох 3.8 хувиас бага байх төлөвтэй байна.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны эхний 4 сард экспортолсон нүүрсний нийт хэмжээ өнгөрсөн оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцсэн нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг 6.0 хувьд хүргэж, цаашид эдийн засгийн үзүүлэлтэд эергээр нөлөөлөхөөр байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд байгаа тул Засгийн газраас инфляцын сөрөг нөлөөллийг бууруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан нөхцөл байдлуудаас шалтгаалан Монгол Улсын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

--- оОо ---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2023 он	2024 он	2025 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	10.0	8.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	20,781.9	21,163.2	22,472.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.5	32.3	30.9
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	22,371.4	22,996.1	23,928.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.2	35.1	32.9
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	4,211.7	624.7	932.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7.0	1.0	1.3
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,589.5	-1,832.9	-1,456.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.6	-2.8	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,616.2	5,850.4	6,145.6

	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9.3	8.9	8.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	39,125.5	39,276.0	43,704.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	65.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,209.0	2,153.8	2,241.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.7	3.3	3.1

2 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 он



**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл болж байна.

Практик шаардлага

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны эхний 4 сард экспортолсон нүүрсний нийт хэмжээ өнгөрсөн оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцсэн бөгөөд 2023 оны эдийн засгийн өсөлт 6.0 хувьд хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн орлого давж биелэх хүлээлттэй байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газраас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн

албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах чиглэлээр багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Түүнчлэн нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, авто замын сүлжээг өргөтгөх зам, замын байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг нийслэлийн үнэт цаас гаргах замаар санхүүжүүлж, төсөв хооронд зохицуулалт хийж, шийдвэрлэх шаардлага бий болж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах зардал, хөрөнгийн зардлын хэмжээ, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилт, жагсаалтад өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар инфляцын сөрөг нөлөөлөл багасаж хүүхэд, ахмад настан, төрийн албан хаагчдын орлогын баталгаа нэмэгдэх, иргэдийн амьдрах орчин сайжрах, хотын түгжрэл буурах зэргээр иргэдийн амьдралын баталгаа сайжирна.

Дээрх багц арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг төсвийн тэнцвэржүүлсэн орлогын давалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт болон хүүгийн төлбөрийн хэмнэлтээс санхүүжүүлэх боломжтой.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 он

АГУУЛГА

НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ	3
1.1. Төсвийн тодотгол хийх үндэслэл	3
1.2. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд.....	4
1.3. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал.....	4
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ.....	6
НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО	7
3.1. Монгол Улсын 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл.....	7
3.2. Төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ.....	7
3.3. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл.....	8
НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА	9
4.1. Төсвийн урсгал зарлага	9
4.2. Төсвийн хөрөнгө оруулалт.....	9
4.3. Засгийн газрын гадаад зээл, тусламж.....	10
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	11
5.1. Орон нутгийн төсөв	11
5.2. Орон нутгийн хөгжлийн сан	11
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР.....	12
ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	13

ХҮСНЭГТ

Хүснэгт 1 Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг).....	4
Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэншлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь).....	5
Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл.....	5
Хүснэгт 4. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр (ДНБ-д эзлэх хувь).....	5
Хүснэгт 5. 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	7
Хүснэгт 6. 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (их наяд)	8

I

НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ**1.1. Төсвийн тодотгол хийх үндэслэл**

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны эхний 4 сард экспортолсон нүүрсний нийт хэмжээ өнгөрсөн оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцсэн бөгөөд 2023 оны эдийн засгийн өсөлт 6.0 хувьд хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн орлого давж биелэх хүлээлттэй байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газраас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах, гол дагуух дэд бүтэц болон нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх “Холбоос зам” төслийг 2023 онд нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх дүнгээс 187.0 тэрбум төгрөгийг бууруулах замаар санхүүжүүлэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан төсөв хооронд зохицуулалт хийх замаар шийдвэрлэх шаардлага бий болж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үндэслэл:

- ☐ 34.1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх;
- ☐ 34.1.2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;



- ☐ 34.1.3. Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн
- ☒ 34.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх;
- ☐ 34.1.5. Хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны хөрөнгө хүрэлцэхгүй болсон;

1.2. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,732.3 тэрбум төгрөгөөр өсөж 20.8 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага мөн 1,896.1 тэрбум төгрөгөөр өсөж 22.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт алдагдлын хэмжээ 1.6 их наяд төгрөг буюу батлагдсан дүнгээс 163.8 тэрбум төгрөгөөр өсөхөөр тооцооллоо.

Хүснэгт 1 Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023 БАТ	2023 ТОД	ЗӨРҮҮ
НИЙТ ОРЛОГО	19,722.3	21,823.5	2,101.2
Тогтворжуулалтын сан	132.7	501.6	368.9
Ирээдүй өв сан	540.0	540.0	0.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	19,049.6	20,781.9	1,732.3
НИЙТ ЗАРЛАГА	20,475.3	22,371.4	1,896.1
Урсгал зардал	15,247.5	16,914.1	1,666.6
Хөрөнгийн зардал	5,359.7	5,616.1	256.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-132.0	-159.0	-27.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-1,425.7	-1,589.5	-163.8
ДНБ-д эзлэх хувь	-2.6%	-2.6%	-

1.3. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

☒ Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2023 оны зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,386.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 110.8 ам.доллар байхаар тооцсон.

☒ Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшнийг баримталлаа.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн нэгнцвэржүүлсэн тэнцрийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2023	2024	2025
Хуулийн хязгаар	-3.6%	-2.8%	-2.0%
Төсөөлөл	-2.6%	-2.8%	-2.0%

☒ Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2023 онд 23.2 хувиар өсөх, 2024 онд 2.8 хувиар өсөх, 2025 онд 4.1 хувиар өсөхөөр төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасан төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл

ОСОЛТ	2023	2024	2025
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	23.2%	2.8%	4.1%
Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	23.3%	3.5%	8.0%
Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	15.3%	14.0%	11.7%

☒ Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65.0 хувиас, 2024 оны төсвийн жилд 60.0 хувиас, 2025 оны төсвийн жилээс эхлэн 60.0 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2023-2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 4. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр (ДНБ-д эзлэх хувь)

	2023	2024	2025
Хуулийн хязгаар	65.0%	60.0%	60.0%
Төсөөлөл	65.0%	60.0%	60.0%

III

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

Эдийн засгийн өсөлтийг 2023 оны жилийн эцэст 6.0 хувьд хүрэхээр төсөөлж байна. Оюутолгойн далд уурхай болон газрын тосны олборлолт нэмэгдэж, уул уурхайн салбарын борлуулалтын гэрээ бүртгэлийн үр дүнд тус салбарын үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүргэх зорилтыг хангаснаар 2023 онд уул уурхай, тээврийн салбар тус тус 15.0 орчим хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжихээр байна. Мөн авто болон төмөр зам, эрчим хүчний төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжсэнээр барилгын салбарын өсөлтийг дэмжихээр байна. Харин оны эхэнд өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, малын хорогдол өндөр байсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарахаар байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн өсөлт цаашид хадгалагдаж 2023 оны жилийн эцсээр 22.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 3.4 орчим тэрбум ам.долларын ашигтай байхаар хүлээгдэж байна. Хилийн боомтууд дээр хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлтийн ажлуудын үр дүнд нүүрсний экспорт 50.0 сая тоннд хүрч, экспортын хэмжээ 12.8 орчим тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Мөн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаатай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон дизель түлш, машин механизм зэрэг үйлдвэрлэлийн орцын бүтээгдэхүүний импорт нэмэгдсэнээр нийт импортын дүн 2023 онд 9.4 орчим тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд авч хэрэгжүүлж буй экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд 2023 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарах боломжтой байна. Засгийн газрын зүгээс өрийн зохицуулалтын хүрээнд 650.0 сая ам.долларын бондыг гадаад зах зээлд амжилттай арилжаалсан нь төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа. Мөн Засгийн газар хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэх, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.

Улсын инфляц 2023 оны эцэст нэг оронтой тоонд хүрэх төлөвтэй байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү өсөж, мөн өмнөх оны суурь үнэ өндөр байсан зэрэг шалтгаануудын улмаас инфляц буурах хүлээлттэй байна. Харин худалдааны түнш орнуудын инфляц эрчимжих, Украинд үүсээд байгаа геополитикийн хямралт байдал, эрчим хүчний үнэ өсөх зэрэг эрсдэл инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

III

НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

3.1. Монгол Улсын 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Энэ оны эхний 4 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 7,108.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс нийт 344.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Хүснэгт 5. 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.4 ТӨЛӨВ	2023.4 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт орлого	6,764.3	7,108.5	344.1
Тогтворжуулалтын сан	42.6	396.1	353.5
Тэнцвэржүүлсэн орлого	6,721.8	6,712.2	-9.5
Татварын орлого	6,197.9	6,386.1	188.3
Татварын бус орлого	523.9	326.1	-197.8

Ийнхүү төсвийн орлого эхний 4 сарын байдлаар давж биелэхэд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайжирсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил эрчимжсэний улмаас эдийн засгийн өсөлт эхний улирлын байдлаар 7.9 хувь гарсан байна. Мөн гадаад худалдааны эргэлт 7.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 50.4 хувиар өссөн байна.

3.2. Төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- ✓ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, боомтуудын ачаа тээврийн нэвтрүүлэх хэсгийг өргөтгөх ажлыг үргэлжлүүлж, голлох боомтуудад шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Татварын бүртгэлийг сайжруулах, цахимжуулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх замаар далд эдийн засгийг бууруулах, татварын суурийг өргөжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Уул уурхайн бүтээгдэхүүнийг нээлттэй арилжих замаар борлуулалт, тээвэрлэлтэд хяналт тавих цогц системийг бий болгох, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжоор хангах, улс орны эдийн засгийн өсөлтөд тус салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор нэвтрүүлж буй “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж”-ийн тогтолцоог дэмжиж ажиллана.

3.3. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Монгол Улсын 2023 оны тэнцвэржүүлсэн орлого 20.8 их наяд төгрөг буюу батлагдсан дүнгээс 1.7 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Хүснэгт 6. 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (их наяд)

ҮЗҮҮЛЭЛТ	2023 ТӨЛӨВ	2023 ХБГ	ЗӨРҮҮ
Тэнцвэржүүлсэн орлого	19.0	20.8	+1.7

Энэ онд Засгийн газраас хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, голлох боомтууд болох Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудаар нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүнд 2023 оны эхний 4 сарын байдлаар нийт 19.6 сая.тн нүүрс экспортолж, өмнөх оны мөн үеэс 16 сая тонноор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Цаашид экспортолж буй байгалийн баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, экспортын үйл ажиллагааг саадгүй үргэлжлүүлэх, хилийн нэвтрүүлэх чадлыг тогтвортой хадгалах, хилээр нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр нийт 50.0 сая тонн нүүрс экспортлохоор тооцлоо. Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний үр дүнд уул уурхайн салбараас нийт 6.1 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

IV

НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА**4.1. Төсвийн урсгал зарлага**

Төсвийн нийт урсгал зардал 2023 онд 16.9 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 60 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 14.0 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 16.0 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 6.0 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 4.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

Тодотголын хуулийн төслийн хүрээнд дараах урсгал зардлын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгалаа.

- Төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэчлэл
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгоно.
- Тэтгэврийн зөрүүг арилгаж, инфляцаар нэмэгдүүлнэ.
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, зарим тэтгэмжийг нэмэгдүүлнэ
- Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулна.
- Залуучуудын хөгжлийг дэмжинэ.
- Биений тамир, спортын үйл ажиллагааг дэмжинэ.
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

4.2. Төсвийн хөрөнгө оруулалт

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн “29.3.6.тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх” гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлж байгаа гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг огт бууруулахгүй байх зарчмыг баримталаа.

Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах зарчмын хүрээнд АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Төв цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрээс ДЦС-3, ДЦС-4 рүү уг дахин боловсруулсан усыг нийлүүлэх шугам хоолойн угсралтын ажлын худалдан авах ажиллагааны дагуу гэрээг байгуулах ажил хийгдэж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан 2023 онд батлагдсан санхүүжилтээс тодорхой хувийг гүйцэтгэлээр санхүүжүүлж авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын VI.2.1.2 хуулийн дугаартай “Гадаадын зээл, тусламжаар

хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/” төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг нийт 43,507.5 сая төгрөгийг Мянганы сорилтын сангийн холбогдох тооцоололд үндэслэн бууруулсан.

Бууруулсан санхүүжилтийн дүнгээс нэн шаардлагатай дараах 2 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нэмж тусгалаа. Үүнд:

1. Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын багцад сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийн зардал болох 15,967.1 сая төгрөг;
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад Улсын бүртгэлийн ерөнхий газрын шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал болох 18,540.4 сая төгрөгийг тус тус тусгалаа.

4.3. Засгийн газрын гадаад зээл, тусламж

Засгийн газрын гадаад зээл оны эхний 5 сарын байдлаар 308.2 тэрбум төгрөг буюу 25.2 хувийн гүйцэтгэлтэй, тусламж 51.8 тэрбум төгрөг буюу 9.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголын төсөлд дараах зарчмыг баримталаа. Үүнд:

- ✓ 2023 оны хүлээгдэж гүйцэтгэлээр зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй шинэ сэргэлтийн бодлогод туссан хөгжлийн томоохон төслүүд эрчимтэй хэрэгжихээр тооцогдож байгаа тул төсвийн тодотголд санхүүжилтийг батлагдсан түвшинд үлдээх;
- ✓ Нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг 2023 онд нэн тэргүүнд санхүүжүүлэх болон дуусах төслүүдийн санхүүжилтийг бүрэн олгох;
- ✓ Зээлийн хэлэлцээр байгуулагдсан ч бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил нь эхлээгүй төслүүдийн санхүүжилтийг хойшлуулах замаар төслийн хэрэгжилттэй нь уялдуулан зарим төслийн хөрөнгийг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Тухайлбал, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн ЕРС-4 буюу Лицензтэй технологийн байгууламжийн багц ажлын 7 барилгын (Устөрөгчийн үйлдвэр, Бензин боловсруулалт, Висбрекинг, Хүхэр ялгалт, Дизелийн Гидроцэвэрлэгээ, Шингэн шахмал хийн цэвэрлэгээ, Гидрокрекинг) зураг төслийн 2023 оны гүйцэтгэл төлөвлөгдсөн дүнгээс давсан тул 40.0 тэрбум төгрөгийн зохицуулалтыг төсвийн тодотголд тусгалаа.

V

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ**5.1. Орон нутгийн төсөв**

Эдийн засгийн идэвхжилийг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд орон нутгийн төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, хувь хүний орлогын албан татварын орлого нэмэгдэхээр тооцлоо.

Орон нутгийн 2023 оны төсвийн суурь орлого, суурь зарлагад орсон өөрчлөлтүүдийн үр дүнд аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг 43.0 тэрбум төгрөгөөр өсөж 2023 онд 257.2 тэрбум төгрөг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 12.0 тэрбум төгрөгөөр буурч 2023 онд 1,016.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Нийслэлийн Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, автозамын сүлжээг өргөтгөх зам, замын байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг нийслэлийн үнэт цаас гаргах замаар санхүүжүүлж, төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэнэ.

5.2. Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан /ОНХНС/ болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 2023 оны төсвийн тодотголын төсөлд 369.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2023 оны батлагдсан төсвийн дүнгээс 71.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нэмэгдэлтэй холбоотой юм.

V

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 31.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 52.4 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

Засгийн газрын зүгээс олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр зах зээлийн цонх үеийг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири 2” төслийн хүрээнд 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, нийт 650.0 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж хугацаа тулаад байсан “Гэрэгэ” бондоос 435.3 сая ам.доллар, “Хуралдай” бондоос 209.3 сая ам.доллартой тэнцэх хэсгийг дахин санхүүжүүлсэн. Мөн тус өрийн зохицуулалтын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр төлөгдөх хуваарьтай байсан “Гэрэгэ” бондын үлдэгдлээс 82.0 сая ам.доллартой тэнцэх төлбөрийг улсын төсвийн мөнгөн хөрөнгөөс төлснөөр хугацаа тулаад байсан өрийн хэмжээг бууруулж Монгол Улсын дефолтын эрсдэлийг бүрэн хаасан болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2023 онд 65.0 хувиас хэтрэхгүй байхаар заасан байдаг бөгөөд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа 2023 оны жилийн эцсээр 54.3 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын зүгээс “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилго бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг гаргаад байгаа билээ. Үүнийг санхүүжүүлэхээр Өрийн удирдлагын тухай хуулийн 28^{1.1}-т заасан зориулалтын дагуу Нийслэлийн үнэт цаас гаргахаар 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Нийслэлийн засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг батлуулсан болно. Иймд Өрийн удирдлагын тухай хуулийн 28^{1.6.2}, 28^{1.6.3}-т заасан шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

VII

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэл

Коронавируст халдварын цар тахал болон ОХУ-Украйн улс хооронд үүсээд байсан хурцадмал байдлын нөлөөгөөр агшаад байсан дэлхийн эдийн засагт сэргэлт ажиглагдаж эхэллээ. Гэсэн хэдий ч БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тодорхой бус төсөөлөл нь төсвийн орлогын биелэлтэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Манай экспортын бүтээгдэхүүний гол худалдан авагч болох БНХАУ-ын үл хөдлөх салбарт уналт үргэлжилж, эдийн засгийн сэргэлт удаашрах хандлагатай болсон нь эрдэс бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Ингэснээр дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлтэй байна.

Нэг. Дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах: Геополитикийн тогтворгүй нөхцөл байдал улам хурцдах, үнийн өсөлт үргэлжлэх, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаан байх зэрэг хүчин зүйлс дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн түүнчлэн томоохон эдийн засаг бүхий хөгжингүй орнуудын инфляцыг бууруулахад чиглэсэн мөнгөний хатуу бодлого нь хөгжиж буй орнуудад санхүүжилт босгоход хүндрэл учруулах эрсдэлтэй хэвээр байна.

АНУ, Швейцарт үүссэн санхүү, эдийн засгийн савлагаа үргэлжилж, олон улсын хөрөнгийн зах зээлээр дамжин дэлхийн бодит эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж болзошгүй байна. Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ буурах зэрэг сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Хоёр. Эрчим хүчний хангамж: Эрчим хүчний хангамж, хүртээмж, найдвартай байдал, үр ашигтай зохион байгуулалт нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хэдий ч манай улсын төвлөрсөн эрчим хүч, дулааны хангамжийн систем нь өнөөгийн хурдацтай өсөж буй эрэлтийг хангаж чадахгүй байна. Түүнчлэн эрчим хүчний суурилагдсан хүчин чадал төдийлөн нэмэгдээгүйгээс гадна станцууд¹ 35-60 жил, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ 32-62 жилийн насжилтай байгаа нь хүчин чадлаасаа давсан үйлдвэрлэл явуулж байгаа өнөө үед оргил ачааллын үеэр гэмтэл гарч, нийлүүлэлтийн тасалдалд хүргэх эрсдэл өндөр байна. Энэ нь улмаар бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

¹ Амгалан дулааны станцаас бусад

Гурав. Малын өвчин, цаг агаар, ган зудын эрсдэл: Хөдөө аж ахуйн салбар нь байгаль, цаг уурын нөхцөл байдалтай шууд хамааралтай бөгөөд Монгол орны цаг агаарын дундаж температур 1940 оноос хойш жилд дунджаар 2.2 градусаар нэмэгдэж байна. Цаг агаарын таагүй байдал, халдварт өвчин тархалт нь хөдөө аж ахуй салбарын нийлүүлэлтэд нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, өрхүүдийн бодит орлогыг бууруулах, тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэл байна. Өнгөрсөн онд хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас бага байсан, нийт нутгийн 60 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн, өвөлжилт хүндрэлтэй байсантай холбоотойгоор хаваржилт хүндрэх төлөвтэй байна. Мөн хөдөөгийн өрхийн орлогын 38.0 хувийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд малын зүй бус хоргодол өндөр, малын гоц халдварт өвчний тархалт их болох нь өрхийн орлогыг бууруулж, ажилгүйдлийн түвшин, тэгш бус байдал, Засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Дөрөв. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитик, цар тахлын хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед зээлжих зэрэглэл буурах, аливаа төрлийн хоригт өртөхгүй байх нь чухал байна. Иймд, манай улс олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөж, харилцан ойлголцож, зээлжих зэрэглэл тогтоох болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх шаардлагатай. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

--- оОо ---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 он

АГУУЛГА

НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ	4
1.1 Төсвийн тодотгол хийх үндэслэл	4
1.2 Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд	5
1.3 Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал	5
МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЙЛБАР - ЗҮЙЛ ТУС БҮРЭЭР	7
1 дүгээр зүйл	7
2 дугаар зүйл	7
3 дугаар зүйл	8
4 дүгээр зүйл	8
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ	9
3.1 Макро эдийн засгийн оноогийн нөхцөл байдал	9
3.2 Макро эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	13
3.3 Гадаад эдийн засгийн хандлага	13
3.3.1 Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	13
3.3.2 Түүхий эдийн зах зээлийн хандлага	15
НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО	18
4.1 Монгол Улсын 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл	18
4.2 Төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэл	18
4.3 Төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ	18
4.4 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл	19
НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА	20
5.1 Төсвийн урсгал зарлага	20
5.1.1 Төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэчлэл	20
5.1.2 Хүүхдийн монгол тэтгэмжийг хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгоно	21
5.1.3 Тэтгэврийн зөрүүг арилгаж, инфляцаар нэмэгдүүлнэ	22
5.1.4 Нийгмийн халамжийн тэтгэвэр, зарим тэтгэмжийг нэмэгдүүлнэ	22
5.1.5 Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулна	22
5.1.6 Залуучуудын хөгжлийг дэмжинэ	22
5.1.7 Биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжинэ	23
5.1.8 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана	23
5.2 Төсвийн хөрөнгө оруулалт	23
5.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2023 онд	23
5.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, салбараар	24
5.2.3 Төсвийн тодотголд улсын төсвийн хөрөнгө оруулалтын баримтлах зарчим	25
5.3 Засгийн газрын гадаад зээл, тусламж	25
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	27
6.1 Орон нутгийн төсөв	27
6.2 Орон нутгийн хөгжлийн сан	27
ЗАСГИЙН ГАЗРЫН ОР	28
ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГУЙ БУСАД ЭРСДЭЛ	30

ЗУРАГ

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц (улирлаар)	9
Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь).....	11
Зураг 3. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)	11
Зураг 4. ГВАН, хүрэлцээт түвшин (сая ам.доллар).....	11
Зураг 5. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)	12
Зураг 6. Дэлхийн эдийн засгийн өсөлт (хувь).....	15
Зураг 7. Зэсийн үнэ (ам.доллар, тонн).....	15
Зураг 8. Алтны үнэ (ам.доллар, трой унци).....	16
Зураг 9. Төмрийн хүдрийн үнэ (ам.доллар, тонн)	16
Зураг 10. Нүүрсний үнэ (ам.доллар, тонн).....	16
Зураг 11. Газрын тосны үнэ (ам.доллар, баррель).....	17
Зураг 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг).....	23

ХҮСНЭГТ

Хүснэгт 1 Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг).....	5
Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн тосоолол (ДНБ-д эзлэх хувь)	6
Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн тосоолол.....	6
Хүснэгт 4. Засгийн газрын орлын тосоолол, оноогийн үнэ цэнээр (ДНБ-д эзлэх хувь).....	6
Хүснэгт 5. Эдийн засгийн өсөлтийн бүтэц (нэгж хувь).....	9
Хүснэгт 6. Улсуудын эдийн засгийн өсөлт (хувь).....	14
Хүснэгт 7. 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	18
Хүснэгт 8. 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (их наяд).....	19
Хүснэгт 9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл (сая төгрөг).....	24
Хүснэгт 10. Засгийн газрын орлын бүтэц (тэрбум төгрөг)	28

I

НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ**1.1. Төсвийн тодотгол хийх үндэслэл**

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны эхний 4 сард экспортолсон нүүрсний нийт хэмжээ өнгөрсөн оны эхний 9 сарын хэмжээтэй дүйцсэн бөгөөд 2023 оны эдийн засгийн өсөлт 6.0 хувьд хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн орлого давж биелэх хүлээлттэй байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газраас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах, гол дагуух дэд бүтэц болон нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх “Холбоос зам” төслийг 2023 онд нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх дүнгээс 187.0 тэрбум төгрөгийг бууруулах замаар санхүүжүүлэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан төсөв хооронд зохицуулалт хийх замаар шийдвэрлэх шаардлага бий болж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үндэслэл:

- ☐ 34.1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх;
- ☐ 34.1.2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;



- ☐ 34.1.3. Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн
- ☒ 34.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх;
- ☐ 34.1.5. Хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны хөрөнгө хүрэлцэхгүй болсон;

1.2. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,732.3 тэрбум төгрөгөөр өсөж 20.8 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага мөн 1,896.1 тэрбум төгрөгөөр өсөж 22.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт алдагдлын хэмжээ 1.6 их наяд төгрөг буюу батлагдсан дүнгээс 163.8 тэрбум төгрөгөөр өсөхөөр тооцооллоо.

Хүснэгт 1 Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023 БАТ	2023 ТОД	ЗӨРҮҮ
НИЙТ ОРЛОГО	19,722.3	21,823.5	2,101.2
Тогтворжуулалтын сан	132.7	501.6	368.9
Ирээдүй өв сан	540.0	540.0	0.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	19,049.6	20,781.9	1,732.3
НИЙТ ЗАРЛАГА	20,475.3	22,371.4	1,896.1
Урсгал зардал	15,247.5	16,914.1	1,666.6
Хөрөнгийн зардал	5,359.7	5,616.1	256.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-132.0	-159.0	-27.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-1,425.7	-1,589.5	-163.8
ДНБ-д эзлэх хувь	-2.6%	-2.6%	-

1.3. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

☒ **Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2023 оны зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,386.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 110.8 ам.доллар байхаар тооцсон.

☒ **Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшнийг баримталаа.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл (ДНБ-д эзлэх хувь)

	2023	2024	2025
Хуулийн хязгаар	-3.6%	-2.8%	-2.0%
Төсөөлөл	-2.6%	-2.8%	-2.0%

☒ Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2023 онд 23.2 хувиар өсөх, 2024 онд 2.8 хувиар өсөх, 2025 онд 4.1 хувиар өсөхөөр төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасан төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл

ОСОЛТ	2023	2024	2025
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	23.2%	2.8%	4.1%
Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	23.3%	3.5%	8.0%
Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	15.3%	14.0%	11.7%

☒ Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65.0 хувиас, 2024 оны төсвийн жилд 60.0 хувиас, 2025 оны төсвийн жилээс эхлэн 60.0 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2023-2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 4. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр (ДНБ-д эзлэх хувь)

	2023	2024	2025
Хуулийн хязгаар	65.0%	60.0%	60.0%
Төсөөлөл	65.0%	60.0%	60.0%

II

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЙЛБАР - ЗҮЙЛ ТУС БҮРЭЭР

1 дүгээр зүйл.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар оорчлон найруулсугай:

1/3: 3 дугаар зүйл - 1.1 Төсвийн тодотгол хийх үндэслэл бүлэгт дурдсаны дагуу Монгол Улсын төсөвт 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын шинэчилсэн дүнг хүснэгтээр тусгасан.

2/6: 6 дугаар зүйл - 1.1 Төсвийн тодотгол хийх үндэслэл бүлэгт дурдсаны дагуу Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардлын шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

3/12: 12 дугаар зүйл - Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.1-т заасан зориулалтын нэмж тусгасан. Энэ нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын зүгээс хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилго бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн арга хэрэгсэлтэй холбоотой өөрчлөлт бөгөөд дэлгэрэнгүй тайлбарыг 7. Засгийн газрын өр бүлэгт тусгасан болно.

4/16-18: 16 дугаар зүйл - Монгол Улсын 2023 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан. Үүгээр эдийн засгийн идэвхжилийг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, хувь хүний орлогын албан татварын орлого нэмэгдэхээр тооцсон болно.

17 дугаар зүйл - Монгол Улсын 2023 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан. Үүгээр төрийн албаны цалингийн шинэчлэл болон Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилго бүхий төсөл, хөтөлбөрийн хүрээнд гарсан өөрчлөлтүүдийг тооцсон бөгөөд дэлгэрэнгүй тайлбарыг 6. Орон нутгийн төсөв бүлэгт тусгасан.

18 дугаар зүйл – Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын 2023 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан. Энэ талаар 6. Орон нутгийн төсөв бүлэгт дэлгэрэнгүй тусгасан.

2 дугаар зүйл.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын төсвийн хоронгоор 2023 онд санхүүжүүлэх хоронго оруулалтын тосол,

арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралтаар оорчлон найруулсугай.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад байгаа АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл 2023 онд батлагдсан санхүүжилтээс тодорхой хувийг гүйцэтгэлээр санхүүжүүлж авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул төслийн санхүүжилтийг бууруулж нэн шаардлагатай 2 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нэмж тусгасан бөгөөд 5.2.3 Төсвийн тодотголд улсын төсвийн хөрөнгө оруулалтын баримт зарчим хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

3 дугаар зүйл.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "13,910,441.9" гэснийг "15,184,583.6" гэж, 7 дугаар зүйлийн "15,480,800.3" гэснийг "16,949,914.4" гэж, 8 дугаар зүйлийн "2,695,015.3" гэснийг "2,672,455.3" гэж, 10 дугаар зүйлийн "132,718.6" гэснийг "501,628.6" гэж тус тус өөрчилсүгэй.

Хуулийн төслийн өөрчлөлтүүдтэй холбогдуулан Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарцуулах төсвийн зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэх хэмжээ болон Төсвийн тогтворжуулалтын санд 2023 оны төсвийн жилд хуримтлуулах хэмжээг тус тус шинэчлэн тусгасан.

4 дүгээр зүйл.

Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэхүү хуулийн дагаж мөрдөх огноог заасан.

III


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн:

Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны эхний улиралд 13.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 42.1 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн бодит өсөлтийг салбараар авч үзвэл, уул уурхайн салбар 49.6 хувиар, тээврийн салбар 76.3 хувиар, худалдааны салбар 9.3 хувиар, барилгын салбар 0.2 хувиар тэлсэн нь нийт өсөлтийг дэмжсэн бол боловсруулах салбар 6.7 хувиар, хөдөө аж ахуйн салбар 5.1 хувиар, цэвэр татвар 3.6 хувиар агшсан нь нийт өсөлтийг хязгаарлалаа.

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц (улирлаар)



Хүснэгт 5. Эдийн засгийн өсөлтийн бүтэц (нэгж хувь)

ҮЗҮҮЛЭЛТ	2019	2020	2021	2022	2022.I	2023.I
Эдийн засгийн өсөлт	5.6	-4.6	1.6	4.8	-3.9	7.9
Хөдөө аж ахуй	0.7	0.8	-0.8	1.7	0.5	-0.2
Үйлдвэрлэл	0.9	-1.3	-0.6	-0.8	-7.0	5.0
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-1.6	-6.1	5.3
Боловсруулах	0.3	0.3	-0.1	0.5	-0.7	-0.5
Цахилгаан дулаан	0.1	0.0	0.2	0.1	0.2	0.2
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2	-0.4	0.0
Үйлчилгээ	2.9	-3.0	1.8	2.6	1.1	3.8
Худалдаа	1.2	-1.4	0.6	0.9	0.7	1.0
Тээвэр	0.2	-1.0	-0.3	0.1	-1.4	2.1
Бусад	1.5	-0.6	1.5	1.6	1.8	0.6
Цэвэр татвар	1.0	-1.1	1.3	1.4	1.6	-0.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний улиралд эдийн засгийн өсөлтийн 7.4 нэгж хувийг уул уурхай болон тээврийн салбар бүрдүүлэв. Өмнөх оны эхний улиралтай харьцуулахад уул уурхайн салбар 49.6 хувиар өссөн нь нүүрс олборлолт 3.3 дахин, газрын тосны олборлолт 31.3 дахин, зэсийн баяжмалын үйлдвэрлэл 28.6 хувиар нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Түүнчлэн, уул уурхайн салбарын тэлэлтийг дагасан авто замын нүүрс тээвэр нэмэгдсэн нь тээврийн салбарын өсөлтөд нөлөөлөв.

Уул уурхайн бус эдийн засгийн өсөлт 3.0 хувь байна. 2023 оны I дүгээр улиралд худалдаа, үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин барилгын салбарын хувьд орон сууцны болон орон сууцны бус барилгын ажил нэмэгдсэн ч инженерийн барилга, байгууламж, засварын ажил буурсан нь салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй ойролцоо түвшинд, өсөлт багатай байхад хүргэжээ. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад төл бойжилт 35.8 хувиар буурч, малын зүй бус хорогдол 14.2 дахин өссөн нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурахад нөлөөллөө. Боловсруулах салбарын хувьд нэхмэл, хувцас зэрэг хөнгөн үйлдвэрлэл буурсан нь салбарын өсөлтийг хязгаарлалаа.

Эдийн засгийн дотоод эрэлт 2023 оны эхний улиралд хүлээлтээс доогуур буюу өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар, хөрөнгийн хуримтлал 26.5 хувиар тус тус буурсан. Харин бараа, үйлчилгээний импорт 55.7 хувиар, экспорт 2.4 дахин өсөж, цэвэр экспорт өмнөх оныхоос 45.0 хувиар сайжирсан нь өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Өрхийн сарын дундаж бодит орлого эхний улиралд өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурсан. Хэдийгээр өрхүүдийн цалингийн орлого 16.1 хувиар өссөн ч тэтгэвэр, тэтгэмжийн орлого 15.9 хувиар, мал аж ахуйгаас орох орлого 34.7 хувиар тус тус өмнөх оны мөн үеэс буурсан. Орлогын бууралтыг байршлаар авч үзвэл аймгийн төвийн айлуудынх 1.9 хувиар, нийслэлийн өрхүүдийнх 5.1 хувиар буурсан бол сумын төвийн өрхүүдийнх 8.7 хувиар, хөдөөгийн өрхүүдийнх 7.6 хувиар тус тус буурч хөдөөд амьжиргаа илүү хүндэрсээр байна.

Өрхүүдийн бодит орлого буурахын хажуугаар иргэдийн хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл нэмэгдсэн. Иргэдийн банкнуудаас шинээр авсан цалин, тэтгэврийн зээл оны эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 49.3 хувиар буюу 712.0 тэрбум төгрөгөөр, хадгаламж барьцаалсан зээл 10.5 хувиар буюу 175.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хөрөнгийн хуримтлал оны эхний улиралд өмнөх оноос 26.5 хувиар буурлаа. Өвөлжилт хүндэрч төл бойжилт буурч, мөн экспорт идэвхэжсэнээр эрдэс бүтээгдэхүүний хуримтлагдсан овоолго багассан зэргээс шалтгаалан эргэлтийн хөрөнгө 70.7 хувиар буурсан нь хөрөнгийн хуримтлалын бууралтад голлон нөлөөллөө. Зээл олголт, төсвийн хөрөнгө оруулалт оны эхэнд нэмэгдсэн ч эдийн засагт орох гаднын хөрөнгө урсгал багасаж, үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх оны түвшнээс 2.5 хувиар буурсан байна.

Үнийн өсөлт: Инфляц 2022 оны 06 дугаар сард оргил үедээ буюу 16.1 хувьд хүрсэн бол аажмаар буурч 2023 оны 04 дүгээр сарын байдлаар 11.3 хувьд хүрээд байна.



Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад валютын албан нөөц өссөнөөр валютын зах зээл тогтворжсон, худалдааны түнш орнуудын инфляц буурч байгаа зэргээс шалтгаалан сүүлийн саруудад инфляцын түвшин буурсан хэдий ч Монголбанкны зорилтот түвшнээс хоёр дахин өндөр хэвээр байна.

Засгийн газраас гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнд төгрөгийн ханш сулрах дарамт буурснаар импортын


барааны инфляц буурч байна.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 4 сарын байдлаар өмнөх оноос 10.0 хувиар өсөж, 30.2 их наяд төгрөгт хүрэхэд төгрөгийн харилцах 29.0 хувь, валютын харилцах 12.5 хувь, валютын хадгаламж 22.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Мөнгөний нийлүүлэлтийг эх үүсвэр (актив) талаас нь авч үзвэл дотоодын зах зээлийн зээл олголт өссөн нь голчлон нөлөөллөө.

Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2023 оны 4 сарын байдлаар өмнөх оноос 4.2 хувиар өсөж 23.5 их наяд төгрөгт хүрэхэд 4.8 нэгж хувийг хэрэглээний болон хадгаламж барьцаалсан зээл, 1.0 нэгж хувийг бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын зээл голлон бүрдүүлжээ. Арилжааны банкнуудын нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл 5.9 хувь, чанаргүй зээл 9.7 хувь байна.




Зураг 3. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4. ГВАН, хүрэлцээт түвшин (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк, тооцоолол

Төлбөрийн тэнцэл: БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогоос шалтгаалсан хил, гаалийн саатлаас үүдэлтэй экспортын бууралт, өмнөх онд урьдчилж борлуулсан нүүрсний экспорттой холбоотой экспортын бодит орлогын тасалдал болон импортын өсөлт зэргээс шалтгаалан 2022 онд төлбөрийн тэнцлийн дарамт өндөр байв. Засгийн газрын зүгээс валютын орлого төвлөрүүлэх, экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох, хяналтыг сайжруулах, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн гэрээг ил тод болгох чиглэлээр цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Төлбөрийн тэнцэл 2023 оны эхний улирлын байдлаар 80.0 сая ам.долларын ашигтай гарч, 2022 оны 8 дугаар сарын дунд 2.4 тэрбум ам.долларт хүрч буураад байсан гадаад валютын албан нөөц 2023 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар 3.7 тэрбум ам.доллар болж нэмэгдлээ. Мөн төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2022 оны 9 дүгээр сард өдөрт дунджаар 6.5 төгрөгөөр суларч байсан бол 2023 оны 4 дүгээр сард өдөрт дунджаар 2.1 төгрөгөөр чангарлаа.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 оны эхний 4 сарын байдлаар 7.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 50.4 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.



Зураг 5. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт өмнөх оны мөн үеэс 81.6 хувиар өсөж 5.1 тэрбум ам.долларт хүрэхэд нүүрсний экспорт 2.9 дахин буюу 1.9 тэрбум ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв. 2023 оны эхний улиралд коксжих нүүрсний гадаад эрэлт тогтвортой байснаас гадна 2022 оны хоёрдугаар хагасаас эхлэн хилийн боомт дахь тээврийн саатал арилсан нь нүүрсний экспорт сэргэхэд нөлөөллөө.

Импорт өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өсөж, 2.7 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн худалдан авсан байна. Дээрх

өсөлтийн 7.8 нэгж хувийг үнийн өөрчлөлт, 5.4 нэгж хувийг биет хэмжээний өөрчлөлт бүрдүүлжээ. 2022 онд импортын үнийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж байсан дизель түлшний үнийн өсөлт тогтворжиж, нүүрсний экспорт нэмэгдэж байгаатай холбоотойгоор биет хэмжээний өсөлт нь импортын өсөлтөд голлох нөлөө үзүүллээ. Мөн уул уурхайн салбарын өсөлтийг дагаж ачаа тээврийн зориулалттай том машины импорт нэмэгдэж байна.

Сүүлийн саруудад өрхийн бодит орлого буурсаар байгаа нь хүнсний бүтээгдэхүүний импорт буурахад нөлөөллөө. Хүнсний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 18.8 хувь буурсан бөгөөд голчлон биет хэмжээний бууралтаас шалтгаалсан байна.

3.2. Макро эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлтийг 2023 оны жилийн эцэст 6.0 хувьд хүрэхээр төсөөлж байна. Оюутолгойн далд уурхай болон газрын тосны олборлолт нэмэгдэж, уул уурхайн салбарын борлуулалтын гэрээ бүртгэлийн үр дүнд тус салбарын үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүргэх зорилтыг хангаснаар 2023 онд уул уурхай, тээврийн салбар тус тус 15.0 орчим хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжихээр байна. Мөн авто болон төмөр зам, эрчим хүчний төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжсэнээр барилгын салбарын өсөлтийг дэмжихээр байна. Харин оны эхэнд өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, малын хорогдол өндөр байсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарахаар байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн өсөлт цаашид хадгалагдаж 2023 оны жилийн эцсээр 22.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 3.4 орчим тэрбум ам.долларын ашигтай байхаар хүлээгдэж байна. Хилийн боомтууд дээр хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлтийн ажлуудын үр дүнд нүүрсний экспорт 50.0 сая тоннд хүрч, экспортын хэмжээ 12.8 орчим тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Мөн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаатай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон дизель түлш, машин механизм зэрэг үйлдвэрлэлийн орцын бүтээгдэхүүний импорт нэмэгдсэнээр нийт импортын дүн 2023 онд 9.4 орчим тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд авч хэрэгжүүлж буй экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд 2023 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарах боломжтой байна. Засгийн газрын зүгээс өрийн зохицуулалтын хүрээнд 650.0 сая ам.долларын бондыг гадаад зах зээлд амжилттай арилжаалсан нь төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа. Мөн Засгийн газар хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэх, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.

Улсын инфляц 2023 оны эцэст нэг оронтой тоонд хүрэх төлөвтэй байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү өсөж, мөн өмнөх оны суурь үнэ өндөр байсан зэрэг шалтгаануудын улмаас инфляц буурах хүлээлттэй байна. Харин худалдааны түнш орнуудын инфляц эрчимжих, Украинд үүсээд байгаа геополитикийн хямралт байдал, эрчим хүчний үнэ өсөх зэрэг эрсдэл инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

3.3. Гадаад эдийн засгийн хандлага

3.3.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Үнийн өсөлтийг хязгаарлахад чиглэсэн мөнгөний хатуу бодлого, геополитикийн хямралт байдал, БНХАУ-ын цар тахлын эсрэг бодлогын шийдвэрүүд зэрэг 2022 оны

эдийн засгийн төлөвийг тодорхойлсон хүчин зүйлс 2023 болон 2024 онд ч дэлхийн эдийн засгийн идэвхжилд голлох нөлөө үзүүлсэн хэвээр байхаар байна. Мөн 2023 оны эхний улиралд зарим улсын банкны салбарт тогтворгүй байдал үүссэн нь дэлхий дахинд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн эрсдэлийн удирдлагыг сайжруулах шаардлагатай байгааг санууллаа.

Дэлхийн улс орнууд үнийн өсөлтийг хязгаарлахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг хадгалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах бодлогын сорилттой нүүр тулж байна. Олон улсын валютын сан (ОУВС)-гийн энэ оны 04 дүгээр сарын тооцооллоор 2023 онд дэлхийн эдийн засаг 2.8 хувиар өсөх бол 2024 онд үнийн өсөлт болон Украинд өрнөж байгаа геополитикийн хурцадмал байдлын сөрөг нөлөө аажмаар саармагжиж, дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацааны төлөв буюу 3.0 хувь орчимд байхаар хүлээгдэж байна. Гэсэн хэдий ч 2023 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.0 хувиас бага байх магадлал 25.0 орчим хувь буюу хэвийн үеэс 2 дахин өндөр байгааг мөн онцолсон байна.

Хүснэгт 6. Улсуудын эдийн засгийн өсөлт (хувь)

	2022	2023	2024
ДЭЛХИЙ	3.4	2.8	3.0
Хөгжингүй орнууд	2.7	1.3	1.4
АНУ	2.1	1.6	1.1
Евро бүс	3.5	0.8	1.4
Япон	1.1	1.3	1.0
Хөгжиж буй орнууд	4.0	3.9	4.2
БНХАУ	3.0	5.2	4.5
ОХУ	-2.1	0.7	1.3

Эх сурвалж: "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайлан, ОУВС, 2023 оны 4 дүгээр сар

БНХАУ: Цар тахлын хөл хориог цуцалсантай холбоотойгоор эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, БНХАУ-ын эдийн засаг 2023 оны эхний улиралд өмнөх оноос 4.5 хувиар, өмнөх улирлаас 2.2 хувиар тус тус өсөөд байна. БНХАУ 2023 оны эдийн засгийн өсөлтийг 5.0 хувь орчимд хүргэх зорилтыг зарласан бол ОУВС-аас тус улсын эдийн засгийг 2023 онд 5.2 хувиар, 2024 онд 4.5 хувиар тус тус өснө гэж тооцоолж байна.


ОХУ: Украинд үүсээд байгаа геополитикийн хямралт байдал үргэлжилж, 2023 оны эхний улиралд ОХУ-ын эдийн засаг 2.2 хувиар агшсан байна. Тус улсын эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ нэмэгдэж байгаа нь ОХУ-ын эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байна. ОУВС-аас тус улсын эдийн засгийг 2023 онд 0.7 хувиар, 2024 онд 1.3 хувиар тус тус өснө гэж тооцоолж байна.

АНУ: АНУ-ын инфляц зорилтот түвшнээс өндөр хэвээр байгаа ч Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогыг чангаруулах эрчмийг бууруулж, бодлогын хүүгийн өсөлтийг

75.0 нэгж хувиас 25.0 нэгж хувь болгон бууруулаад байна. Мөнгөний чанга бодлого хэрэглээ, хөрөнгө оруулалтаар дамжин эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж, АНУ-ын эдийн засгийн өсөлт 2023 онд 1.6 хувь, 2024 онд 1.1 хувь байна гэж ОУВС тооцоолж байна.

Евро бүс: Европын төв банк инфляцын өсөлтийг хязгаарлах зорилгоор хасах хүүгийн бодлогоо зогсоож, бодлогын хүүг нэмэгдүүлж байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. Мөн ОХУ-ын байгалийн хийн нийлүүлэлтийн бууралтаас үүдэлтэй Европын эрчим хүчний хямралын эрсдэл хэвээр байна. Эрчим хүчний үнийн өсөлт, мөнгөний чанга бодлогын нөлөөгөөр тус бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд 0.8 хувьд хүрч буурах ч 2024 онд 1.4 хувь болж нэмэгдэхээр хүлээгдэж байна.


Зураг 6. Дэлхийн эдийн засгийн өсөлт (хувь)



3.3.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага


Зэсийн үнэ 2023 оны эхний 4 сард дунджаар 8,928.0 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 1.6 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлт удаашрах болон БНХАУ-ын үл хөдлөх, барилгын салбарын хямрал үргэлжилж болзошгүй зэрэг эрсдэлээс шалтгаалан зэсийн эрэлт 2023 онд өмнөх оноос буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглаж байгаагаар зэсийн дундаж үнэ 2023 онд 8,670.0 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 7. Зэсийн үнэ (ам.доллар, тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Зураг 8. Алтны үнэ (ам.доллар, трой унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

худалдан авах зардлыг нэмэгдүүлсэн. Дэлхийн банкны үзэж байгаагаар 2023 онд ам.долларын ханш суларч, хүү буурах магадлалтай байгаа нь алтны үнэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Олон улсын шинжээчдийн таамаглаж байгаагаар алтны дундаж үнэ 2023 онд 1,840.0 ам.доллар/унц хүрэхээр байна.

Зураг 9. Төмрийн хүдрийн үнэ (ам.доллар, тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

хандлагатай байна.

Зураг 10. Нүүрсний үнэ (ам.доллар, тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Алтны үнэ 2023 оны эхний 4 сард дунджаар 1,917.0 ам.доллар/унц болж, өмнөх оны дунджаас 6.3 хувиар өслөө. Украинд нөхцөл байдал хурцдаж эхэлсний дараа алтны үнэ 1 унц нь 2,000 орчим ам.доллар буюу бүх цаг үеийн дээд цэгтээ хүрсэн ч 2022 оны 8 дугаар сараас эхлэн аажмаар буурч 11-р сард 1,700 орчим ам.доллар болов. Төв банкууд бодлогын хүүгээ өсгөж эхэлснээр алтанд хөрөнгө оруулалт хийх сонирхлыг бууруулсны зэрэгцээ ам.долларын ханш ихэнх валютын эсрэг чангарч байгаа нь алт

Төмрийн хүдрийн үнэ 2023 оны эхний 4 сард дунджаар 123.0 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 2.1 хувиар өслөө. БНХАУ 2021 онд үл хөдлөх хөрөнгийн салбарыг дэмжих чиглэлд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн нь гангийн эрэлтийг дэмжиж, төмрийн хүдрийн үнийг эрчимтэй өсгөсөн. Ирэх онд уг төслүүд хэрэгжиж дууссанаар төмрийн хүдрийн эрэлт саарч, нөгөөтээгүүр Бразил, Австралийн төмрийн хүдрийн нийлүүлэлт нэмэгдсэнээр үнэ буурах

Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2023 оны эхний 4 сард дунджаар 330.0 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 9.0 хувиар буурлаа. 2022 оны 3 дугаар сараас эхлэн ОХУ-ын байгалийн хийн нийлүүлэлт тасалдаж, үнэ өссөнөөр Европт эрчим хүчний хямрал бий болсон. Улмаар Евро бүсийн улсуудад өвөлжилт хүндэрснээр нүүрсний эрэлт нэмэгдэж 2022 онд үнэ өссөн. 2023 онд байгалийн хийн нийлүүлэлт тасалдсан хэвээр байвал нүүрсний эрэлтэд эерэг нөлөө үзүүлнэ гэж Дэлхийн банк үзэж

байна. Мөн БНХАУ цар тахлын хөл хориогоо сулруулснаар тус улсын эрчим хүч болон коксжих нүүрсний хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна. Энэ онд нүүрсний үнэ 2022 оны түвшнээс буурах хэдий ч цар тахлын өмнөх түвшнээс өндөр хэвээр байна. Олон улсын шинжээчдийн таамаглаж байгаагаар нүүрсний үнэ 2023 онд буурах хандлагатай байна.

Брент газрын тосны үнэ 2023 оны эхний 4 сард дунджаар 82.0 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 16.8 хувиар буурлаа. Украинд үүсээд байгаа геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалан ОХУ-ын эсрэг авч буй худалдааны хориг арга хэмжээ 2023 онд хэрхэн үргэлжлэх нь тодорхой бус байгаа тул газрын тосны нийлүүлэлтийг төсөөлөхөд хүндрэлтэй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт буурч, улс орнуудын инфляцын түвшин өндөр байгаа нь эрэлт талд сөрөг нөлөөтэй. Олон улсын шинжээчдийн таамаглаж байгаагаар газрын тосны үнэ 2023 онд 82.0 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 11. Газрын тосны үнэ (ам.доллар, баррель)



Эх сурвалж: Блүүмберг терминал

IV

НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО**4.1. Монгол Улсын 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл**

Энэ оны эхний 4 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 7,108.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс нийт 344.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Хүснэгт 7. 2023 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.4 ТӨЛӨВ	2023.4 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт орлого	6,764.3	7,108.5	344.1
Тогтворжуулалтын сан	42.6	396.1	353.5
Тэнцвэржүүлсэн орлого	6,721.8	6,712.2	-9.5
Татварын орлого	6,197.9	6,386.1	188.3
Татварын бус орлого	523.9	326.1	-197.8

Ийнхүү төсвийн орлого эхний 4 сарын байдлаар давж биелэхэд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайжирсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил эрчимжсэний улмаас эдийн засгийн өсөлт эхний улирлын байдлаар 7.9 хувь гарсан байна. Мөн гадаад худалдааны эргэлт 7.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 50.4 хувиар өссөн байна.

4.2. Төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэл

Коронавируст халдварын цар тахал болон ОХУ-Украйн улс хооронд үүсээд байсан хурцадмал байдлын нөлөөгөөр агшаад байсан дэлхийн эдийн засагт сэргэлт ажиглагдаж эхэллээ. Гэсэн хэдий ч БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тодорхой бус төсөөлөл нь төсвийн орлогын биелэлтэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Манай экспортын бүтээгдэхүүний гол худалдан авагч болох БНХАУ-ын үл хөдлөх салбарт уналт үргэлжилж, эдийн засгийн сэргэлт удаашрах хандлагатай болсон нь эрдэс бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Ингэснээр дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлтэй байна.

4.3. Төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

- ✓ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, боомтуудын ачаа тээврийн нэвтрүүлэх хэсгийг өргөтгөх ажлыг

үргэлжлүүлж, голлох боомтуудад шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

- ✓ Татварын бүртгэлийг сайжруулах, цахимжуулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх замаар далд эдийн засгийг бууруулах, татварын суурийг өргөжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Уул уурхайн бүтээгдэхүүнийг нээлттэй арилжих замаар борлуулалт, тээвэрлэлтэд хяналт тавих цогц системийг бий болгох, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжоор хангах, улс орны эдийн засгийн өсөлтөд тус салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор нэвтрүүлж буй “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж”-ийн тогтолцоог дэмжиж ажиллана.

4.4. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Монгол Улсын 2023 оны тэнцвэржүүлсэн орлого 20.8 их наяд төгрөг буюу батлагдсан дүнгээс 1.7 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Хүснэгт 8. 2023 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (их наяд)

ҮЗҮҮЛЭЛТ	2023 ТӨЛӨВ	2023 ХБГ	ЗӨРҮҮ
Тэнцвэржүүлсэн орлого	19.0	20.8	+1.7

Энэ онд Засгийн газраас хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, голлох боомтууд болох Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудаар нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүнд 2023 оны эхний 4 сарын байдлаар нийт 19.6 сая.тн нүүрс экспортолж, өмнөх оны мөн үеэс 16.0 сая тонноор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Цаашид экспортолж буй байгалийн баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, экспортын үйл ажиллагааг саадгүй үргэлжлүүлэх, хилийн нэвтрүүлэх чадлыг тогтвортой хадгалах, хилээр нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр нийт 50.0 сая тонн нүүрс экспортлохоор тооцлоо. Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний үр дүнд уул уурхайн салбараас нийт 6.1 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

V

НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

5.1. Төсвийн урсгал зарлага

Төсвийн нийт урсгал зардал 2023 онд 16.9 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 60.0 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 14.0 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 16.0 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 6.0 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 4.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.



5.1.1. Төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэчлэл

Цалин хөлс: Төрийн албаны цалингийн шинэчлэлийн хүрээнд хэт олон сүлжээ, шатлал бүхий харилцан адилгүй, тэгш бус үнэлэмжтэй төрийн албаны цалингийн тогтолцоог нэгтгэх замаар адил үнэлэмж бүхий ажил хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчийн цалин ижил байх зарчимд нийцүүлээ. Цалин хөлсний энэхүү шинэчлэлтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

Төрийн захиргааны албан хаагч: Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдын цалингийн сүлжээг яамны, нийслэлийн харьяа байгууллагын, бусад төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гэж ангилан баталсан. Эдгээр 3 ялгаатай цалингийн сүлжээг нэгтгэн нэг цалингийн сүлжээтэй байхаар тооцож, төрийн захиргааны албан хаагчдын цалингийн зөрүүг ойртуулна. Төрийн захиргааны албан хаагчийн цалингийн доод хэмжээг 1.0 сая төгрөгт хүргэх ба үүний үр дүнд бага албан тушаалын албан хаагчдын цалин дунджаар 282.3 мянган төгрөгөөр нэмэгдэхээр байна. Төрийн захиргааны албан хаагчдын цалингийн өсөлттэй уялдуулан төрийн өндөр албан тушаалтан болон ажлын албаны цалингийн сүлжээг шинэчилнэ.

Төрийн тусгай албан хаагч: Цагдаа, дотоодын цэргийн болон бусад төрийн тусгай албан хаагчийн цалингийн хэмжээ ялгаатай байгааг өөрчилж, цалингийн нэг сүлжээ мөрдөхөөр шинэчилнэ. Шинэчилсэн цалингийн сүлжээг хэрэгжүүлэхэд төрийн тусгай албаны бага болон дунд албан тушаалтны цалингийн хэмжээ дунджаар 242.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, цалингийн зөрүү арилах боломжтой болно. Харин цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээг одоогийн түвшнээс 21.0 хувиар нэмэгдүүлсэн.

Төрийн үйлчилгээний албан хаагч: Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, шинжлэх ухаан, биеийн тамир спортын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг 1.0 сая төгрөгт хүргэхээр тооцоолсон. Харин төрийн байгууллагын хэвийн үйл

ажиллагааг хангах чиг үүрэг бүхий нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг 750.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлэхээр тооцоолсон.

Төрийн улс төрийн зарим албан хаагч: Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ шинэчлэгдэж, хамгийн бага албан тушаалын цалингийн хэмжээг 1.0 сая төгрөгт хүргэж байгаатай холбоотойгоор баг хороо, сум дүүрэг, аймаг нийслэлийн Засаг дарга, түүний орлогчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, багийн Засаг даргын цалингийн хэмжээг 1,250.0 мянган төгрөгөөр тогтооно.



5.1.2. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгоно.

Эдийн засгийн нөхцөл байдал, төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд хүүхдийн мөнгийг 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 91.0 хувьд олгохоор тооцож 2023 оны төсвийг УИХ-аас баталсан. Энэ оны эхний 4 сарын байдлаар 1,143.4 мянган хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаж байна.

Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 2022 оны 1 дүгээр улиралд 3.9 хувиар агшаад байсан эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өссөн байна. Уул уурхайн салбарын сэргэлт, түүхий эдийн үнийн өсөлт, эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр давж биелэхээр байна.

Дээр дурдсан эдийн засгийн эерэг өөрчлөлттэй уялдуулан Засгийн газраас хүүхдийн мөнгийг хүсэлт гаргасан өрхийн хүүхдэд олгохын зэрэгцээ энэ оны 1 дүгээр сараас хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд хүсэлт гаргасан тохиолдолд 2023 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн нөхөж олгохоор төлөвлөөд байна. Үүнтэй холбогдуулан “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн төсөл боловсруулав.



5.1.3.Тэтгэврийн зөрүүг арилгаж, инфляцаар нэмэгдүүлнэ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “тэтгэврийн зөрүүг ойртуулах” зорилтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэврийн хэмжээг 2 үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөлөө.

2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт өндөр настны тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг тогтооход баримталсан цалин хөлсийг 2022 оны дундаж цалингаар суурь болгон шинэчлэн тооцно. Энэ арга хэмжээний үр дүнд ижил цалин хөлсөөр ойролцоо хугацаанд ажиллан шимтгэл төлсөн боловч тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамаарч хоорондоо зөрүүтэй тэтгэвэр авч байгаа 164.6 мянган өндөр настны тэтгэврийн зөрүүг арилгана. Үүний зэрэгцээ тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулж 10.0 хувь нэмэхээр тооцсон ба 496.3 мянган хүний тэтгэвэр нэмэгдэхээр байна.



5.1.4.Нийгмийн халамжийн тэтгэвэр, зарим тэтгэмжийг нэмэгдүүлнэ

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцлоо. Нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүсээгүй хүнд олгох халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж тус бүр 288.0 мянган төгрөг байгааг нэгэн адил 325.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлэх, түүнчлэн нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж 84.5 мянган төгрөг байгааг 275.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлэх, мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмж 123.1 мянган төгрөг байгааг 275.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлнэ. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 144.4 мянган хүн хамрагдана.

5.1.5.Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулна.

“Хүүхдийн төлөө сан”-ийн хуримтлагдсан орлогоос бүтээн байгуулалт болон олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцож амжилт гаргасан хүүхдүүдийг шагнаж урамшуулах зардлыг 2023 оны төсөвт нэмж тусгасан.

5.1.6.Залуучуудын хөгжлийг дэмжинэ.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу хүн амын 29.8 хувийг эзэлдэг 15-34 насны залуучуудын хөгжил болон нийгмийн зарим асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээнд шаардлагатай төсвийг нэмэгдүүлсэн.

5.1.7. Биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжинэ.

Улс орноо таниулан сурталчлах, олон улсын зүгээс хүлээлгэсэн итгэлийг бататган тив, дэлхийн хэмжээний спортын их наадмуудыг эх орондоо зохион байгуулах, эрхийн төлөө өрсөлдөх, эрх авах, хүүхэд залуусаа спортоор хичээллэх сонирхолтой болгох, олон улсын тэмцээнүүдэд оролцож амжилт гаргах боломжийг бүрдүүлэх, шагнаж урамшуулах зорилгоор Монгол Улсад “Зүүн Азийн залуучуудын наадам”, “Улаанбаатар их дуулга 2023-наадам” зохион байгуулахад шаардагдах зардлыг төлөвлөж тусгасан.

5.1.8. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана


УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор хууль тогтоомжийн системчлэл, хуулийн лавлагаа мэдээлэл, сургалт сурталчилгаа, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас Хууль зүйн үндэсний хүрээлэнг Улсын Их Хурлын Тамгын газрын даргын багцад шилжүүлэхээр шийдвэрлэсэн тул холбогдох өөрчлөлтийг тусгав.

5.2. Төсвийн хөрөнгө оруулалт

5.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2023 онд

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 7,385.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2,695.0 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1137 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан, мөн өмнөх онуудад концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн гэрээний эргэн төлөлтөд 4 төслийн 279.6 тэрбум төгрөг, нийт 2,974.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд нийт төслийн 78.0 хувь нь 2023 онд ашиглалтад орохоор төлөвлөсөн.

Зураг 12 Улсын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2023 онд нийт 10.5 их наяд төгрөгийн батлагдсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 20.1 хувьтай буюу 598.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна. Үүнээс 159.5 тэрбум төгрөг нь барилгын материалын үнийн өсөлтөд олгосон санхүүжилт буюу нийт олгохоор батлагдсан үнийн өсөлтийн санхүүжилтийн гүйцэтгэл 54 хувьтай байна.

5.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, салбараар:

Хүснэгт 9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл (сая төгрөг)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсвийн тоо	2023 онд дуусав	Төсөвт орлог	2023 онд батлагдсан санхүүжилт	Санхүүжилт	Хувь	Үлдэгдэл
Монгол улсын шадар сайд	3	2	10,345.7	7,543.8	366.1	4.85%	7,177.8
Монгол улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	2	1	55,634.1	43,193.8	344.1	0.80%	42,849.7
Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	31	26	84,828.5	23,091.1	5,212.4	22.57%	17,878.7
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	24	24	48,769.3	18,492.1	2,160.6	11.68%	16,331.5
Батлан хамгаалахын сайд	6	6	24,031.6	11,865.6	1,532.6	12.92%	10,333.0
Сангийн сайд	6	3	494,518.5	245,402.0	15,712.8	6.40%	229,689.2
Хууль зүй, дотоод хэргийн сайд	24	20	88,145.6	41,557.7	11,591.5	27.89%	29,966.2
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	33	23	132,989.6	36,841.3	8,611.1	23.37%	28,230.1
Барилга, хот байгуулалтын сайд	169	126	974,575.9	345,152.5	65,950.5	19.11%	279,202.1
Боловсрол, шинжлэх ухааны сайд	399	303	1,634,389.2	529,281.5	129,827.9	24.53%	399,453.6
Соёлын сайд	77	66	546,000.8	144,237.3	30,311.2	21.01%	113,926.1
Зам, тээврийн хөгжлийн сайд	120	102	1,577,015.7	408,821.9	51,203.5	12.52%	357,618.4
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	47	36	138,936.7	74,672.5	12,179.4	16.31%	62,493.2
Эрчим хүчний сайд	42	25	482,439.0	168,999.2	25,850.6	15.30%	143,148.7
Эрүүл мэндийн сайд	106	79	469,278.3	172,118.7	42,171.3	24.50%	129,947.4
Улсын ерөнхий прокурор	4	4	27,644.4	13,093.9	10,326.5	78.86%	2,767.4
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	1	572.5	458.0	-	0.00%	458.0
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	5	4	24,546.0	21,625.9	908.3	4.20%	20,717.6
Монгол улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	35	29	162,061.6	48,823.2	18,041.8	36.95%	30,781.3
Монгол улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	3	1	408,523.1	339,743.2	81,666.0	24.04%	258,077.2
Улсын төсвийн дүн	1137	881	7,385,246.2	2,695,015.3	513,968.2	19.07%	2,181,047.1
Концессын дүн	4	4	541,524.7	279,590.4	84,213.9	30.12%	195,376.5

НИЙТ	1141	885	7,926,770.9	2,974,605.7	598,182.1	20.1%	2,376,423.6
------	------	-----	-------------	-------------	-----------	-------	-------------

5.2.3. Төсвийн тодотголд улсын төсвийн хөрөнгө оруулалтын баримтлах зарчим:

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн “29.3.6. тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх” гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлж байгаа гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг огт бууруулахгүй байх зарчмыг баримталаа.

Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах зарчмын хүрээнд АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Төв цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрээс ДЦС-3, ДЦС-4 рүү уг дахин боловсруулсан усыг нийлүүлэх шугам хоолойн угсралтын ажлын худалдан авах ажиллагааны дагуу гэрээг байгуулах ажил хийгдэж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан 2023 онд батлагдсан санхүүжилтээс тодорхой хувийг гүйцэтгэлээр санхүүжүүлж авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын VI.2.1.2 хуулийн дугаартай “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/” төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг нийт 43,507.5 сая төгрөгийг Мянганы сорилтын сангийн холбогдох тооцоололд үндэслэн бууруулсан.

Бууруулсан санхүүжилтийн дүнгээс нэн шаардлагатай дараах 2 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нэмж тусгалаа. Үүнд:

1. Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын багцад сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийн зардал болох 15,967.1 сая төгрөг;
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад Улсын бүртгэлийн ерөнхий газрын шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал болох 18,540.4 сая төгрөгийг тус тус тусгалаа.

5.3. Засгийн газрын гадаад зээл, тусламж

Монгол Улсын 2023 оны төсөвт 1,795.0 тэрбум төгрөгийн гадаадын төслийн зээл, тусламжийг авч ашиглахаар төлөвлөгдсөнөөс эхний 5 сарын гүйцэтгэлээр 360.0 тэрбум төгрөгийг хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас хүлээн авч, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд байна.

Засгийн газрын гадаад зээл оны эхний 5 сарын байдлаар 308.2 тэрбум төгрөг буюу 25.2 хувийн гүйцэтгэлтэй, тусламж 51.8 тэрбум төгрөг буюу 9.1 хувийн гүйцэтгэлтэй

байна. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголын төсөлд дараах зарчмыг баримталлаа. Үүнд:

- ✓ 2023 оны хүлээгдэж гүйцэтгэлээр зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй шинэ сэргэлтийн бодлогод туссан хөгжлийн томоохон төслүүд эрчимтэй хэрэгжихээр тооцогдож байгаа тул төсвийн тодотголд санхүүжилтийг батлагдсан түвшинд үлдээх;
- ✓ Нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг 2023 онд нэн тэргүүнд санхүүжүүлэх болон дуусах төслүүдийн санхүүжилтийг бүрэн олгох;
- ✓ Зээлийн хэлэлцээр байгуулагдсан ч бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил нь эхлээгүй төслүүдийн санхүүжилтийг хойшлуулах замаар төслийн хэрэгжилттэй нь уялдуулан зарим төслийн хөрөнгийг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Тухайлбал, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн ЕРС-4 буюу Лицензтэй технологийн байгууламжийн багц ажлын 7 барилгын (Устөрөгчийн үйлдвэр, Бензин боловсруулалт, Висбрекинг, Хүхэр ялгалт, Дизелийн Гидроцэвэрлэгээ, Шингэн шахмал хийн цэвэрлэгээ, Гидрокрекинг) зураг төслийн 2023 оны гүйцэтгэл төлөвлөгдсөн дүнгээс давсан тул 40.0 тэрбум төгрөгийн зохицуулалтыг төсвийн тодотголд тусгалаа.

VI

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ**6.1. Орон нутгийн төсөв**

Эдийн засгийн идэвхжилийг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд орон нутгийн төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, хувь хүний орлогын албан татварын орлого нэмэгдэхээр тооцлоо.

Орон нутгийн 2023 оны төсвийн суурь орлого, суурь зарлагад орсон өөрчлөлтүүдийн үр дүнд аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг 43.0 тэрбум төгрөгөөр өсөж 2023 онд 257.2 тэрбум төгрөг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 12.0 тэрбум төгрөгөөр буурч 2023 онд 1,016.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Нийслэлийн Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, автозамын сүлжээг өргөтгөх зам, замын байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг нийслэлийн үнэт цаас гаргах замаар санхүүжүүлж, төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэнэ.

6.2. Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан /ОНХНС/ болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 2023 оны төсвийн тодотголын төсөлд 369.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2023 оны батлагдсан төсвийн дүнгээс 71.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нэмэгдэлтэй холбоотой юм.

VII

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 31.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 52.4 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

Хүснэгт 10. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2022
I. Засгийн газрын дотоод өр	1,035.5
1.1 Үнэт цаас	1,035.8
II. Засгийн газрын гадаад өр	29,641.6
2.1 Үнэт цаас	9,359.8
2.2 Зээл	20,281.8
III. Засгийн газрын бусад өр	1,288.7
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	812.9
3.2 "Барих-шилжүүлэх" төрлийн концесс	463.5
3.3 Орон нутгийн зээллэг	12.3
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	31,965.8
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (ӨҮЦ)	27,679.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	52.4%

Засгийн газрын зүгээс олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр зах зээлийн цонх үеийг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири 2” төслийн хүрээнд 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, нийт 650.0 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж хугацаа тулаад байсан “Гэрэгэ” бондоос 435.3 сая ам.доллар, “Хуралдай” бондоос 209.3 сая ам.доллартой тэнцэх хэсгийг дахин санхүүжүүлсэн. Мөн тус өрийн зохицуулалтын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр төлөгдөх хуваарьтай байсан “Гэрэгэ” бондын үлдэгдлээс 82.0 сая ам.доллартой тэнцэх төлбөрийг улсын төсвийн мөнгөн хөрөнгөөс төлснөөр хугацаа тулаад байсан өрийн хэмжээг бууруулж Монгол Улсын дефолтын эрсдэлийг бүрэн хаасан болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2023 онд 65.0 хувиас хэтрэхгүй байхаар заасан байдаг бөгөөд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа 2023 оны жилийн эцсээр 54.3 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын зүгээс “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилго бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг гаргаад байгаа билээ. Үүнийг санхүүжүүлэхээр Өрийн удирдлагын тухай хуулийн 28^{1.1}-т заасан зориулалтын дагуу Нийслэлийн үнэт цаас гаргахаар 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Нийслэлийн засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг батлуулсан болно. Иймд Өрийн удирдлагын тухай хуулийн 28^{1.6.2}, 28^{1.6.3}-т заасан шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

VIII

**ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ
БОЛЗОШГҮЙ БУСАД ЭРСДЭЛ**

Нэг. Дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширах: Геополитикийн тогтворгүй нөхцөл байдал улам хурцдах, үнийн өсөлт үргэлжлэх, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаан байх зэрэг хүчин зүйлс дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн түүнчлэн томоохон эдийн засаг бүхий хөгжингүй орнуудын инфляцыг бууруулахад чиглэсэн мөнгөний хатуу бодлого нь хөгжиж буй орнуудад санхүүжилт босгоход хүндрэл учруулах эрсдэлтэй хэвээр байна.

АНУ, Швейцарт үүссэн санхүү, эдийн засгийн савлагаа үргэлжилж, олон улсын хөрөнгийн зах зээлээр дамжин дэлхийн бодит эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж болзошгүй байна. Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ буурах зэрэг сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

XIX.1.4	Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2018	2023	4,297.5	297.5
XIX.1.5	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	2019	2023	705.3	88.6
XIX.1.6	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	2019	2023	1,275.2	275.2
XIX.1.7	Усан бассейн спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2019	2023	11,944.4	2,944.4
XIX.1.8	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2019	2023	2,420.1	420.1
XIX.1.9	Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	2019	2023	876.0	175.6
XIX.1.10	Спорт цогцолборын барилга, 105 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум/	2019	2023	1,799.1	599.1
XIX.1.11	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/	2019	2023	671.9	98.4
XIX.1.12	Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2019	2023	11,071.9	1,278.5
XIX.1.13	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Дарви сум/	2020	2023	1,451.4	350.5
XIX.1.14	Спорт заалны барилга /Баянхонгор, Шинэжинст сум/	2020	2023	881.0	331.0
XIX.1.15	Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/	2020	2023	1,463.7	314.1
XIX.1.16	Цэнгэлдэх хүрээлэнгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2020	2023	7,068.9	573.0
XIX.1.17	Спорт цогцолборын барилга /Хэнтий, Дадал сум/	2020	2023	2,065.7	279.1
XIX.1.18	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Цэцэг сум/	2020	2023	1,712.5	554.9
XIX.1.19	Спорт заалны барилга /Ховд, Жаргалант сум, Бугат, Хайрхан баг/	2020	2023	1,441.1	273.0
XIX.1.20	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	2021	2023	2,535.8	1,239.0
XIX.1.21	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дорнод, Хэрлэн сум/	2021	2024	12,980.1	8,759.6
XIX.1.22	Спортын ордны барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2021	2023	10,312.5	7,112.5
XIX.1.23	Спорт заалны барилга /Увс, Малчин сум/	2021	2023	1,394.7	210.1
XIX.1.24	Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/	2021	2024	8,576.9	2,000.0
XIX.1.25	Спорт заалны барилга, 500 суудал /Ховд, Зэрэг сум/	2021	2023	3,425.0	1,425.0
XIX.1.26	Хуучин Дархан спортын ордон /Дархан-Уул, Дархан сум/	2021	2023	4,760.7	869.1
XIX.1.27	Спорт заалны барилга /Хэнтий, Хэрлэн сум, Өлзийт тосгон/	2021	2023	1,188.2	235.5
XIX.1.28	Спорт заалны барилга /Төв, Жаргалант сум/	2021	2023	1,383.6	1,083.6
XIX.1.29	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/	2022	2024	12,840.4	4,826.8
XIX.1.30	Спорт цогцолборын барилга /Хэнтий, Баянмөнх сум/	2022	2023	1,850.0	850.0
XIX.1.31	Спорт цогцолборын барилга, 150 суудал /Улаанбаатар, Багахангай дүүрэг, 2 дугаар хороо/	2022	2024	2,412.9	815.6

/сая төгрөгөөр/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XIX.1.32	Спорт цогцолборын барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2022	2023	5,253.9	3,690.9
XIX.1.33	Спорт заалны барилга /Дархан-Уул, Хонгор сум, Салхит баг/	2022	2023	941.3	541.3
XIX.1.34	Усан спорт сургалтын төвийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2022	2024	9,956.5	3,207.0
XIX.1.35	Спорт заалны барилга, 500 суудал /Говь-Алтай, Цогт сум/	2021	2024	4,420.2	1,128.5
XX	МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА			408,523.1	339,743.2
XX.1	I. Барилга байгууламж			90,523.1	67,523.1
	<i>Шинэ</i>			<i>90,523.1</i>	<i>67,523.1</i>
XX.1.1	Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2023	2023	45,523.1	45,523.1
XX.1.2	Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2023	2024	45,000.0	22,000.0
XX.3	III. Тоног төхөөрөмж			318,000.0	272,220.1
	<i>Шинэ</i>			<i>318,000.0</i>	<i>272,220.1</i>
XX.3.1	Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/	2023	2024	318,000.0	272,220.1
XXI	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА			15,967.1	15,967.1
XXI.3	III. Тоног төхөөрөмж			15,967.1	15,967.1
	<i>Шинэ</i>			<i>15,967.1</i>	<i>15,967.1</i>
XXI.3.1	Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2023	2023	15,967.1	15,967.1
	НИЙТ			7,376,246.2	2,686,015.3

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

1. Хууль:

- 1.1. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай
- 1.2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 1.3. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
- 1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 1.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай
- 1.7. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

2. Улсын Их Хурлын тогтоол:

- 2.1. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 2.2. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

ТАНИЛЦУУЛГА

*Төрийн албаны тухай хуульд нэмэлт
оруулах тухай хуулийн
төслийн талаар*

1.Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэг хуулиар зохицуулах талаар

Төрийн албан хаагчдын үндсэн цалин хөлс, ангилал, зэрэглэл, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хуулиар зохицуулж байгаа хэдий ч зарим салбарын хуулиудаар тухайн салбарын албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг зохицуулж байна. Тухайлбал, салбарын хуулиуд (10 орчим)-аар төрийн зарим албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг Улсын Их Хурлын тогтоохоор, мөн салбарын 30 орчим хуулиар төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахтай холбогдох зохицуулалтыг харилцан адилгүй байдлаар зааж өгсөн байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлсний хэмжээ, нийгмийн баталгаа салбарын өөр өөр хуулиар харилцан адилгүй тогтоож байгаа адил албан тушаалд ижил цалин хөлс олгох суурь зарчим хэрэгжихгүй байх, тэгш бус байдал үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иймд дээр дурдсан харилцан адилгүй цалин хөлс, нийгмийн баталгааны зохицуулалтыг үе шаттайгаар өөрчилж, төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгааны нэгдсэн тогтолцоотой болох зорилгоор Төрийн албаны тухай хуульд "Төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ, сүлжээг энэ хуульд заасан журмаар тогтооно." гэсэн заалтыг нэмж тусган, эдгээр заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, дагаж мөрдөх хүртэл хугацаанд бусад хуулиар зохицуулж байгаа төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ энэ хуульд нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шилжилтийн үеийн зохицуулалтыг тус тус тусгалаа.

2.Төрийн албан хаагчийн орон тоонд хязгаар тогтоох талаар

Төрийн албан хаагчдын тоо 2009 онд 148200 байсан бол 2021 онд 225025 хүрч 52 орчим хувиар (Үүнд, төрийн өмчит компанийн 75500 мянган албан хаагчдыг уг тоонд оруулаагүй болно) нэмэгджээ. Нэг талаар энэ нь өргөн уудам нутаг дэвсгэрт тархан суурьшсан хүн амд төрийн үйлчилгээг хүргэх зардал их байгаагийн илрэл юм. Хэдий төр хамгийн том ажил олгогч боловч төрийн үйлчилгээ иргэдэд тэр бүр хүрч чадахгүй байна. Тухайлбал, 2019 оны хөндлөнгийн үнэлгээгээр төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж 64 хувьтай байна. Мөн орон тоо ихсэх тусам үйл ажиллагааны үе шат ч нэмэгдэж хүнд суртал, чирэгдэл гарч, төрийн үйлчилгээний хүртээмжийн бууруулах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2022 оны эцсийн байдлаар манай улсын ажиллах хүчний тоо 1,265,200 байна. Энэ тоог төрийн албан хаагчийн тоотой харьцуулан үзэхэд ажиллах хүчний 18 орчим хувийг төрийн албан хаагчид эзэлж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнууд төрийн албан хаагчийн тоогоо тодорхойлохдоо ажиллах хүчний

тоотой харьцуулан авч үздэг байна. Тухайлбал, төрийн албан хаагчдын тоо нийт ажиллах хүчний 15 хувиас хэтрэхгүй байх нь зохистой гэж үздэг байна.

2023 оны I улирлын байдлаар ажиллах хүчний 4 ажилтан тутмын 1 нь улсын секторт ажиллаж байгаа бөгөөд энэхүү нөхцөл байдал хэвээр үргэлжилбэл 2035 он гэхэд ажиллах хүчний 3 ажилтан тутмын нэг нь улсын секторт ажиллах магадлалтай гэсэн тооцоолол гарч байна.

Төрийн албаны тухай хуульд "Төрийн албан хаагчийн тоо ажиллах хүчний 15 хувиас илүүгүй байх" гэсэн нэмэлт оруулж, дагаж мөрдөх болон шилжилтийн үеийн зохицуулалтаар "Нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчдын тоо 2023 онд 16.9 хувиас, 2024 онд 15.7 хувиас, 2025 онд 15 хувиас хэтрэхгүй байхаар бууруулна" гэж тусгав.

3.Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлийн тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүнд албан тушаалын цалин болон нэмэгдэл хөлс, албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн, цолны, зэрэг дэвийн, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэхээр заасан.

Дээр дурдсаны дагуу төрийн албан хаагчид үндсэн цалингаас гадна төрийн захиргааны албан хаагч (6 төрлийн) 41-128 хувь, төрийн тусгай алба (8 төрлийн) 45-208 хувь, төрийн үйлчилгээний алба (18 төрлийн) 49-160 хувь, төрийн улс төрийн алба (2 төрлийн) 30-50 хувийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллыг тус тус авч байна.

Засгийн газраас төрийн албан хаагчид олгож байгаа олон төрлийн нэмэгдлийг үндсэн цалинд нэгтгэх, нэмэгдлийн дээд хэмжээг тогтоож, бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх бодлого баримтлан төрийн албан хаагчид олгох нэмэгдлийн хэмжээг тогтоох зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай байна.

4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллах боломжийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж, эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах зорилтууд туссан. 2022 оны байдлаар төрийн албанд нийт 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагаас 1913 буюу 39.3 хувь нь эрэгтэй, 2951 буюу 60.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Төрийн албанд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт албан хаагчийн 245 буюу 0.5 хувь нь удирдах албанд, 2811 буюу 57.7 хувь нь гүйцэтгэх албанд, 1808 буюу 37.1 хувь нь туслах албанд ажилладаг. Үүнээс төрийн улс төрийн албанд 71, төрийн захиргааны албан тушаалд 533, төрийн тусгай албан тушаалд 38, 4222 хүн буюу төрийн албанд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний 87 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байна. Энэ нь төрийн захиргааны албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж нөхцөл хангалтгүй байгааг илтгэх нэг үзүүлэлт юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн албаны зөвлөлтэй хамтран төрийн албаны шалгалт өгөх болзол, журамд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг өөрчлүүлж, шалгалт авах байрыг хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шалгалт өгөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Гэвч 2022 онд төрийн албаны ерөнхий шалгалтад хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй 3 иргэн оролцож одоогийн байдлаар Архивын ерөнхий газар, Соёлын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт тус тус ажиллаж байгаа нь төрийн албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахад бодитой дэмжлэг болохгүй байна.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт холбогдох нэмэлт оруулан хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг:

“4.7.Төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ, сүлжээг энэ хуульд заасан журмаар тогтооно.

2/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчийн тоо 15 хувиас ихгүй байна.”

3/57 дугаар зүйлийн 57.18 дахь хэсэг:

“57.18.Энэ хуулийн 57.2-т заасан цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь төрийн албан хаагчийн үндсэн цалингийн 100 хувиас хэтрэхгүй байна. Энэ хэсэгт төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний зарим албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдэл хамаарахгүй.”

4/78 дугаар зүйл:

"78 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

78.1.Энэ хуулийн 16.4 дэх хэсгийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

78.2.Энэ хуулийн 4.7 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

78.3.Энэ хуулийн 16.4 дэх хэсгийн дагуу үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчдын тоо 2023 онд 16.9 хувиас, 2024 онд 15.7 хувиас, 2025 онд 15 хувиас тус тус хэтрэхгүй байхаар тус тус бууруулна.

78.4.Энэ хуулийн 4.7 дахь хэсгийг дагаж мөрдөх хугацаанаас өмнө бусад хуулиар зохицуулж байгаа төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ, сүлжээг энэ хуульд нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтын “мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх” гэсний дараа “, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх” гэж, 23.2.2 дахь заалтын “мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх” гэсний дараа

“, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх” гэж, 23.2.3 дахь заалтын “мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурал 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталсан. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Улсын Их Хурлын зарим гишүүд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудаас хуулийн зарим зүйл, заалт болон хэрэгжилтийн байдалтай холбоотой олон санал, хүсэлт Засгийн газарт ирж байна.

Иймд уг хуулийг цаашид төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан нэг мөр ойлгож, хуулийн үндсэн зорилтыг хангаж, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа асуудлыг судлан, тодорхойлсны үндсэн дээр дараах өөрчлөлтийг тусган Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Үүнд:

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор автомашин хэрэглэх байгууллага, үйлчилгээний жагсаалтад "хүүхэд хамгааллын байгууллага" гэж нэмэхээр хуулийн төсөлд тусгасан.

2.Ном худалдан авах зардал хэвлэл захиалгын төлбөрт хамаарч байгаагаас шалтгаалж үндсэн үйл ажиллагаанд хүндрэл гарч байгаа талаар соёлын салбарын байгууллагуудаас ирүүлж байгаа саналыг харгалзан номын санд ном худалдан авах зардлыг хэмнэлтэд хамааруулахгүй байхаар хуулийн төсөлд тусгав.

3.Төрийн ёслол хүндэтгэлийн болон төрийн байгууллагуудын шуурхай албаны автомашин ашиглах хэрэгцээг харгалзан зохих нэмэлтийг 6 дугаар зүйлийн 6.5.19 дахь заалтад тусгав.

4.Иргэд, малчдад цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл хүргэх, отор нүүдлийн үед иргэдээ эргэх, цаг агаарын аюултай нөхцөл, байдлын үед газар дээр нь очиж шалгаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэргээр хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн үйлчилгээг анхан шатанд зохион байгуулж, хүргэх чиг үүргийг цаг хугацаа, орон зайг үл харгалзан үзүүлэх үүрэгтэй багийн Засаг дарга нарт орон нутагт дуудлагын автомашин, такси үйлчилгээ, түрээсийн автомашины үйлчилгээ олдоц хомс зэргийг харгалзан тухай чиг үүргийг хэрэгжүүлэхэд автомашин ашиглах талаарх зохицуулалтыг хуулийн 6.2 дахь хэсэгт нэмэхээр төсөлд тусгав

5.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл буюу дүрэмт хувцастай холбоотой зохицуулалтаас тусгай хувцастай холбоотой хэсгийг хасаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д "Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй" гэж заасантай нийцүүлэхээр тусгалаа.

6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгахаар заасан. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд худалдан авах ажиллагааны оролцогчдын онцлог, нарийн мэргэшил шаардлагатай баримт бичгийг боловсруулах хугацаа зэрэг асуудлаас хамаарч хуулийн дээрх заалтад заасан хугацааг баримтлах боломжгүй нөхцөл үүсэхээр байгааг харгалзан хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болгон өөрчлөхөөр тусгалаа.

7.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т “сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр, шатахуун, дотоод албан томилолтын зардал”-ыг хориглосон нь зайлшгүй ажлын шаардлагаар хийх тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр биечлэн хийх бэлтгэл, галт зэвсэг, хэргийн газрын үзлэгийн сургалт, гал түймэртэй тэмцэх зэрэг сургалтуудыг цахимаар зохион байгуулах боломжгүй тул хүндрэл учирч байна. Иймд төрийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс зайлшгүй нүүр тулсан сургалт, уулзалт хийх, цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулах тодорхой шаардлага үүсээд байгааг харгалзан 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “байж болно” гэснийг хасах өөрчлөлтийг тусгав.

8.Хуулиар тогтоосон хориглосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд зөвхөн ажлаас халах хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг өөрчлөн Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн сахилга бат, зарцуулалтын үр ашиг нэмэгдэхийн зэрэгцээ төрийн үйлчилгээний хүртээмж сайжрах ач холбогдолтой

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.5.20 дахь заалт:

“6.5.20.хүүхэд хамгааллын байгууллага.”

2/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:

“17.2.Энэ хуулийн 6, 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “сум,” гэсний дараа “баг,” гэж, 6.5.19 дэх заалтын “ажиллагаа нь” гэсний дараа “төрийн ёслолын болон шуурхай албаны,” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “12.1.3-т” гэсний дараа “номын сан болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “ажлаас халах” гэснийг “Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “2023” гэснийг “2025” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “байж болно” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Залуучуудын хөгжлийг дэмжих тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар*

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2018 оноос хэрэгжиж байгаа бөгөөд хуульд 15-34 насны залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, оролцоог хувь хүний хөгжил, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн үндсэн 5 чиглэлээр дэмжихээр заасан.

Түүнчлэн мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна гэж заасан. 2023 оны I улирлын байдлаар улсын хэмжээнд бүх аймаг, дүүрэг, зарим сумдад Залуучуудын хөгжлийн 43 төв ажиллаж, амьдрах ухааны сургалт, гэр бүлийн боловсрол, эрүүл амьдралын хэв маяг, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө, хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө зэрэг арга хэмжээнд жилд нийт залуучуудын 40-50 хувийг хамруулж байна. Төв нь аймаг, дүүргийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын албаны нарийн бичгийн дарга, сургалт хариуцсан ажилтан, оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан гэсэн 3 орон тоотой ажиллаж байна. Цаашид залуучуудын хөгжлийн төвийн чиг үүрэг арга хэмжээг гэрээний үндсэн дээр залуучуудын олонхын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах, нийгэмд үйлчилдэг, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр тооцож холбогдох зүйлүүд шинээр нэмэв.

Мөн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан Залуучуудын хөгжлийг дэмжих сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан зарим сангаас санхүүжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй давхацсан, холбогдох бусад сангуудаас санхүүжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжилт хангагдаж байгааг харгалзан цаашид тус сантай хамаарах заалтыг хүчингүй болгох, сангаас санхүүжүүлэх арга хэмжээг залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бусад санхүүжилт, төсөвлөлтөд тусгах шаардлагатай байна.

Иймд дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.1.6-19.1.11 дэх заалт нэмсүгэй:

“19.1.6.орон нутгийн салбар, нэгжийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын уялдааг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг дэмжих арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;

19.1.7.аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, салбарууд дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

19.1.8.залуучуудын хөгжлийг дэмжихэд төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, урамшуулах;

19.1.9.залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх;

19.1.10.Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг аймаг, дүүрэг, сум дахь Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан хүргэх, энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоог магадлан итгэмжлэх, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

19.1.11.Энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоог магадлан итгэмжлэх журмыг батлах.”

2 дугаар зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“20 дугаар зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэг

20.1.Орон нутагт залуучуудад үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвийг ажиллуулна. Залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.2.Залуучуудын хөгжлийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.2.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;

20.2.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах;

20.2.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;

20.2.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;

20.2.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;

20.2.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;

20.2.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах;

20.2.8.хууль тогтоомжид заасан бусад.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан үйлчилгээ болон энэ хуульд заасан чиг үүргийг магадлан итгэмжлэгдсэн залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоогоор гэрээлэн гүйцэтгүүлж болно.

20.4.Залуучуудын хөгжлийн төвийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.”

3 дугаар зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн "Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас" гэснийг "Засгийн газрын холбогдох тусгай сангаас" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын "хөдөлмөрийн болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран" гэснийг "хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "төрийн захиргааны байгууллага" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага" гэж, 15.2 дахь хэсгийн "төв байгууллага баталж, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ." гэснийг "төв байгууллага батална." гэж, 19 дүгээр зүйлийн "19.1.6" дэх заалтын дугаарлалтыг "19.1.12" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, Тавдугаар бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн
тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж, эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах зорилтууд туссан. 2022 оны байдлаар төрийн албанд нийт 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагаас 245 буюу 0.5 хувь нь удирдах албанд, 2811 буюу 57.7 хувь нь гүйцэтгэх албанд, 1808 буюу 37.1 хувь нь туслах албанд ажилладаг. Үүнээс төрийн улс төрийн албанд 71, төрийн захиргааны албан тушаалд 533, төрийн тусгай албан тушаалд 38, төрийн үйлчилгээний албан тушаалд 4222 хүн тус тус ажиллаж байна. Энэ нь төрийн захиргааны албан тушаал, удирдах албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж нөхцөл хангалтгүй байгааг илтгэх нэг үзүүлэлт юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн албаны зөвлөлтэй хамтран төрийн албаны шалгалт өгөх болзол, журамд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг өөрчлүүлж, шалгалт авах байрыг хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шалгалт өгөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Гэвч 2022 онд төрийн албаны ерөнхий шалгалтад хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй 3 иргэн оролцож одоогийн байдлаар Архивын ерөнхий газар, Соёлын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт тус тус ажиллаж байгаа нь төрийн албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахад бодитой дэмжлэг болохгүй байна.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн томилогдсон тохиолдолд тухайн байгууллага дэд даргатай байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.5-40.7 дахь хэсэг нэмсүгэй:

"40.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болно.

40.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар энэ хуулийн 40.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилсон тохиолдолд байгууллага дэд даргатай байна.

40.7.Энэ хуулийн 40.5-д заасан байгууллагын дарга нь өөрийн хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамааран зарим эрхээ дэд даргад шилжүүлж болно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг сурталчлан таниулах, түншлэлээр хэрэгжүүлэх төслүүд, хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээ хийх, бэлэн байдлыг хангах, түншлэлийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх зэрэгт хугацаа шаардлагатай байгааг харгалзан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тооцож хуулийн төсөл боловсруулав.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 31-ний” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Төрийн болон орон нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Манай улсын шинжлэх ухааны салбарын эрдэмтэд дотоод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл, технологийг бий болгох чиглэлд тодорхой ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, олон улсын эрдэм, шинжилгээний сэтгүүлд 755 бүтээл, Scopus мэдээллийн санд Монгол Улсын бүртгэлтэй нийт 853 бүтээл хэвлэгдэж, Монголын эрдэмтдийн бүтээлээс 2022 онд нийт 16,977 удаа эшлэл авсан байна. Түүнчлэн, эрдэмтэн, судлаачид олон улсын 23, дотоодын 255 патент, 100 гаруй ашигтай загвар, зохиогчийн эрх хамгаалж, технологийн заавар 440, ТЭЗҮ 25-ыг боловсруулж, 150 гаруй ажил үйлдвэрлэл практикт нэвтрүүлсэн байна.

Гэсэн хэдий ч шинжлэх ухааны салбарын тодорхой чиглэлээр мэргэжлийн түвшинд судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэдэг төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагууд нь төрийн байгууллага, төрийн өмчит компаниудаас зарласан ажил үйлчилгээний тендерт үндсэн гүйцэтгэгчээр сонгогдож чадахгүй байна. Үүний шалтгаан нь арилжааны банканд тендерийн барьцаа байршуулах данс нээх боломжгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.5-д зааснаар төсвийн хөрөнгөөр барьцаа гаргах боломжгүй, тендерт захиалагчаас тогтоосон санхүүгийн чадавхын үзүүлэлтийг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага хангах боломжгүй зэрэгтэй холбоотой байна. Энэхүү байдал нь дотооддоо хийх боломжтой шинжилгээ туршилтыг гадаадад өндөр үнээр хийлгэх, нөгөө талаас боловсон хүчний болон лабораторийн чадавхгүй дотоодын аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсний улмаас тендер үр дүнгүй болох зэрэг сөрөг үр дагавар гарч байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд холбогдох зохицуулалт хийх замаар монгол эрдэмтдийн чанартай судалгаанд суурилсан бодлого, шийдвэр хэрэгжүүлэх, өрсөлдөх чадвар бүхий технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.15 дахь хэсэг нэмсүгэй:

“3.15.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үйл ажиллагааны тодорхой чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээхтэй холбоотой ажил, үйлчилгээ худалдан авах, захиалгын дагуу тухайн чиглэлийн төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Харилцаа холбооны тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн талаар*

Нам орбитын хиймэл дагуулын сүлжээг харилцаа холбооны үйлчилгээнд ялангуяа өндөр хурдны өргөн зурвасын интернэтийн үйлчилгээнд ашиглаж газар зүйн байрлал харгалзахгүйгээр өндөр хурдны интернэтийн үйлчилгээг дэлхий даяар үзүүлж эхлээд байна. Энэ чиглэлээр Англи Улсын OneWeb, Канад Улсын Telesat, Америкийн нэгдсэн улсын Starlink, Project Kuiper зэрэг компаниуд үйл ажиллагаа эхлүүлэн дэлхийн хэмжээний корпорац болон өргөжиж, өөрсдийн үйлчилгээгээ дэлхийн 20 орчим оронд хүргэж байна. Манай улсын хувьд өргөн уудам газар нутагт тархан суурьшсан иргэдийнхээ харилцаа холбооны хэрэгцээг хангахын тулд Монгол Улсын өнцөг булан бүрд шилэн кабель татаж, харилцаа холбооны дэд бүтэц бий болгох нь өндөр өртөгтэй бөгөөд үр ашиггүй хөрөнгө оруулалт болж байна.

Иймд дээрх байршлуудад оршин суугаа иргэдийнхээ харилцаа холбоо, интернэтийн хэрэгцээг хангах, тоон хуваагдлыг бууруулах, онцгой байдал, бүх нийтийн үүрэгт үйлчилгээнд орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, өрсөлдөөнийг дэмжих чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Дээрх чиглэлийн дагуу нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглан интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд нь Монгол Улсад тус үйлчилгээг явуулахад Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.4.харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, 9.8.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах, 9.10.сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус тус авч үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэхээр байна.

Нөгөө талаар Харилцаа холбооны тухай хуулийн 12.4."Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид мөн зүйлийн 9.8, 9.13, 9.15-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй." гэж заасан байгаа нь нам орбитын хиймэл дагуул сүлжээ ашиглан интернэтийн үйлчилгээг үзүүлэх компанид Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10. сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон тохиолдолд 9.4, 9.8-д заасан бусад тусгай зөвшөөрлүүдийг олгох боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

Иймд тухайн 3 төрлийн тусгай зөвшөөрлийг нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглан интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид олгох боломжийг бүрдүүлэх, Монгол Улсад үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх, зах зээлийн өрсөлдөөн бий болгох, харилцаа холбооны дэд бүтэц хүрээгүй алслагдмал газарт амьдарч байгаа иргэдэд харилцаа холбооны, интернэтийн үйлчилгээ хүргэж, тоон хуваагдлыг бууруулах зорилгоор Харилцаа холбооны тухай хуулийн 12.4 дэх хэсгийн "9.10," гэснийг хасаж, өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн "9.10," гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
УИХ-ын тогтоолын төслийн талаар*

Эдийн засгийн нөхцөл байдал, төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд хүүхдийн мөнгийг 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 91 хувьд олгохоор тооцож 2023 оны төсвийг баталсан. Энэ оны эхний 4 сарын байдлаар 1,143.4 мянган хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаж байна.

Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 2022 оны 1 дүгээр улиралд 3.9 хувиар агшаад байсан эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өссөн байна. Уул уурхайн салбарын сэргэлт, түүхий эдийн үнийн өсөлт, эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.3 их наяд төгрөгөөр давж биелэхээр байна.

Дээр дурдсан эдийн засгийн зэрэг өөрчлөлттэй уялдуулан Засгийн газраас хүүхдийн мөнгийг хүсэлт гаргасан өрхийн хүүхдэд олгохын зэрэгцээ энэ оны 1 дүгээр сараас хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд хүсэлт гаргасан тохиолдолд 7 дугаар сарын 1-ээс эхлэн нөхөж олгохоор төлөвлөөд байна. Үүнтэй холбогдуулан “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн төслийг боловсруулав.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт нэмсүгэй:

“4/2023 оны 1-6 дугаар саруудад хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаагүй хүүхдэд 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэн уг хугацаанд ногдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох;

5/эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн мөнгөн тэтгэмжээ Хүүхдийн төлөө санд шилжүүлэх хүсэлт гаргасан бол уг зохицуулалтыг холбогдох журамд тусгах.”

2.Мөн тогтоолын 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэн Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд 100,000 (зуун мянга) төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг сар бүр олгосугай.”

3.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах
тухай УИХ-ын тогтоолын төслийн
талаар*

Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн Л.Оюун-Эрдэнэ хүүхдийн төлөө байгууллагын үе үеийн төлөөлөлтэй 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хийсэн уулзалтаас гарсан зөвлөмжийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиг үүргийг өөрчлөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгох болсонтой холбогдуулан тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлтэй уялдуулж чиг үүргийн зохицуулалт хийх зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “17. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” гэснийг “17. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар” гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР**

1.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“4.7.Төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ, сүлжээг энэ хуульд заасан журмаар тогтооно.”

Тайлбар: Төрийн албан хаагчдын үндсэн цалин хөлс, ангилал, зэрэглэл, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хуулиар зохицуулж байгаа хэдий ч зарим салбарын хуулиудаар тухайн салбарын албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг зохицуулж байна. Тухайлбал, салбарын хуулиуд (10 орчим)-аар төрийн зарим албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг Улсын Их Хурлын тогтоохоор, мөн салбарын 30 орчим хуулиар төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахтай холбогдох зохицуулалтыг харилцан адилгүй байдлаар зааж өгсөн байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлсний хэмжээ, нийгмийн баталгааг салбарын өөр өөр хуулиар харилцан адилгүй тогтоож байгаа нь адил албан тушаалд ижил цалин хөлс олгох суурь зарчим хэрэгжихгүй байх, тэгш бус байдал үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иймд дээр дурдсан харилцан адилгүй цалин хөлс, нийгмийн баталгааны зохицуулалтыг үе шаттайгаар өөрчилж, төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгааны нэгдсэн тогтолцоотой болох зорилгоор 4.7 дахь хэсгийг хуульд шинээр нэмж, үйлчлэлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, дагаж мөрдөх хүртэл хугацаанд бусад хуулиар зохицуулж байгаа төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ энэ хуульд нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шилжилтийн үеийн зохицуулалтыг журам хэлбэрээр тусгасан

1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“16.4.Үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчийн тоо 15 хувиас ихгүй байна.”

Тайлбар: Улсын хэмжээнд 2022 оны байдлаар нийт 225.0 мянган төрийн албан хаагч ажиллаж байгаагаас төрийн захиргааны албанд 22.0 мянган /9.8 хувь/ албан хаагч, төрийн улс төрийн албан тушаалтан 3.8 мянган /1.7 хувь/, төрийн тусгай албанд 47.2 мянган албан хаагч /20.9 хувь/, төрийн үйлчилгээний 152.2 мянган /67.6 хувь/ албан хаагч байна. Төрийн үйлчилгээний 152.2 мянган албан хаагчийн 65.3 хувь буюу 99.5 мянган албан хаагч төрийн үйлчилгээний мэргэжлийн салбарын (боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэнд) албанд, 34.7 хувь буюу 52.7 мянган албан хаагч төрийн үйлчилгээний бусад байгууллагад ажиллаж байна.

Төрийн албан хаагчид үндсэн цалингаас гадна төрийн захиргааны албан хаагч дунджаар 40.0 хувийн, төрийн үйлчилгээний албан хаагч 55.0 хувийн, төрийн тусгай албан хаагч 80.0 хувийн нэмэгдлийг үндсэн цалин дээрээ нэмж авч байна. Орон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний орон нутгийн нэмэгдэл

олгохоор шийдвэрлэсэн. Уг нэмэгдлийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал 80 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Одоогийн байдлаар 20 хувиас дээш нэмэгдлийг нийт 14 аймаг олгож байна. Тухайлбал, Говьсүмбэр аймаг 100 хувь, Өмнөговь аймаг 80 хувь, Орхон аймаг 60 хувь, Сэлэнгэ, Ховд аймаг 50 хувь, Баянхонгор, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг 40 хувь гэх мэт. Мөн гүйцэтгэлээр санхүүжилт авч буй эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарт бүтээмжийн болон гүйцэтгэлийн нэмэгдэл хөлс, урамшуулал авах боломжтой болсон.

Иймд төрийн албан хаагчид олгож байгаа олон төрлийн нэмэгдлийг үндсэн цалинд нэгтгэн нэмэгдлийн хэмжээг хязгаарлаж, бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх бодлогыг баримтлан “цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь төрийн албан хаагчийн үндсэн цалингийн 100 хувиас хэтрэхгүй байх” гэсэн агуулга бүхий хэсэг шинээр нэмэхээр тусгав. Энэ заалтад төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний зарим албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдэл хамаарахгүй байхаар тооцсон.

1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“57.18.Энэ хуулийн 57.2-т заасан цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь төрийн албан хаагчийн үндсэн цалингийн 100 хувиас хэтрэхгүй байна. Энэ хэсэгт төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний зарим албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдэл хамаарахгүй.”

1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“78 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

78.1.Энэ хуулийн 16.4 дэх хэсгийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тайлбар: Үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчийн тоо 15 хувиас ихгүй байх хязгаарлалт нь хууль батлагдсанаас хойш багадаа гурван жилийн хугацаанд үе шаттай мөрдөх замаар нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нь зүйтэй гэж үзсэн тул зорилтод 15 хувийг 2026 оноос мөрдөхөөр тусгасан.

78.2.Энэ хуулийн 4.7 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Тайлбар: Төрийн албаны цалин хөлсний тогтолцооны шинэчлэлийг 2023-2024 онуудад хийхээр төлөвлөж байгаа бөгөөд үүнд үндсэн цалингийн нэгдсэн сүлжээ болон нэмэгдлийн төрөл, хувь хэмжээг бүх салбарт жигд, шударга байхаар өөрчлөх зорилт тавьж байна. Энэ хүрээнд Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан цалин хөлсний зохицуулалтыг жигдлэх бөгөөд үүнтэй уялдуулж “Төрийн

албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ, сүлжээг энэ хуульд заасан журмаар тогтооно” гэсэн нэмэлт хэсгийг 2025 оноос мөрдөхөөр тусгасан.

78.3.Энэ хуулийн 16.4 дэх хэсгийн дагуу үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчдын тоо 2023 онд 16.9 хувиас, 2024 онд 15.7 хувиас, 2025 онд 15 хувиас тус тус хэтрэхгүй байхаар тус тус бууруулна.

Тайлбар: Үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчийн тоо 15 хувиас ихгүй байх хязгаарлалт нь хууль батлагдсанаас хойш багадаа гурван жилийн хугацаанд үе хэрэгжүүлэх замаар нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нь зүйтэй гэж үзсэн тул зорилтод 15 хувийг 2026 оноос мөрдөхөөр тусгасан бөгөөд энэ хүртэл хугацаанд төрийн албан хаагчдын тоог үе шаттай бууруулахаар тооцсон.

78.4.Энэ хуулийн 4.7 дахь хэсгийг дагаж мөрдөх хугацаанаас өмнө бусад хуулиар зохицуулж байгаа төрийн албан хаагчийн цалин хөлс, түүний хэмжээ, сүлжээг энэ хуульд нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ."

Тайлбар: Төрийн албаны цалин хөлсний тогтолцооны шинэчлэлийг 2023-2024 онуудад хийхээр төлөвлөж байгаа бөгөөд үүнд үндсэн цалингийн нэгдсэн сүлжээ болон нэмэгдлийн төрөл, хувь хэмжээг бүх салбарт жигд, шударга байхаар өөрчлөх зорилт тавьж байна. Энэ хүрээнд бусад хууль тогтоомжид заасан цалин хөлсний зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нийцүүлэхээр төлөвлөсөн тул энэхүү нэмэлтийг оруулсан.

2 дугаар зүйл Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтын "мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх" гэсний дараа ", хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх" гэж, 23.2.2 дахь заалтын "мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх" гэсний дараа ", хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх" гэж, 23.2.3 дахь заалтын "мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх" гэсний дараа "хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх" гэж тус тус нэмсүгэй.

Тайлбар: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж, эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах зорилтууд туссан. 2022 оны байдлаар төрийн албанд нийт 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагийн 245 буюу 0.5 хувь нь удирдах албанд, 2811 буюу 57.7 хувь нь гүйцэтгэх албанд, 1808 буюу 37.1 хувь нь туслах албанд ажиллаж байна. Мөн төрийн улс төрийн албанд 71, төрийн захиргааны албан тушаалд 533, төрийн тусгай албан тушаалд 38, төрийн үйлчилгээний албан тушаалд 4222 хүн ажиллаж байна. Энэ нь төрийн захиргааны

албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж нөхцөл хангалтгүй байгааг харуулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн албаны зөвлөлтэй хамтран төрийн албаны шалгалт өгөх болзол, журамд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг өөрчлүүлж, шалгалт авах байрыг хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шалгалт өгөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Гэвч 2022 онд төрийн албаны ерөнхий шалгалтад хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй 3 иргэн оролцож одоогийн байдлаар Архивын ерөнхий газар, Соёлын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт тус тус ажиллаж байгаа нь төрийн албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахад бодитой дэмжлэг болохгүй байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт холбогдох нэмэлт оруулан хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн энэхүү нэмэлттэй уялдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болох, ийнхүү томилсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дэд даргатай байх, түүнчлэн дэд даргад хуульд заасан зарим эрхээ шилжүүлж болох зэрэг зохицуулалтуудыг нэмж оруулсан.

2.ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.5.20 дахь заалт нэмэх:

“6.5.20.хүүхэд хамгааллын байгууллага.”

Тайлбар: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх үүднээс Төрийн хэмнэлтийн хуульд заасан автомашин хэрэглэх байгууллага, үйлчилгээний жагсаалтад дээр дурдсан байгууллага, үйлчилгээний чиглэлийг нэмж оруулахаар хуулийн төсөлд тусгасан.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор автомашин хэрэглэх байгууллага, үйлчилгээний жагсаалтад "хүүхэд хамгааллын байгууллага" гэж нэмэхээр хуулийн төсөлд тусгасан.

1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 17.2 дахь хэсэг нэмэх:

"17.2.Энэ хуулийн 6, 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг журмыг Засгийн газар батална."

Тайлбар: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээс харахад Тээврийн хэрэгсэл (6 дугаар зүйл) болон Цахим худалдан авалт (14 дүгээр зүйл) гэсэн зүйлүүдэд заасан зохицуулалтыг нарийвчилсан журам гаргаж зохицуулах практик шаардлага гарч байгаа тул нэмэлтээр оруулсан.

2 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "сум" гэсний дараа "баг" гэж, 6.5.19 дэх заалтын "ажиллагаа нь" гэсний дараа "төрийн ёслолын болон шуурхай албаны," гэж 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн "12.1.3-т" гэсний дараа "номын сан болон" гэж нэмэх.

Тайлбар:

1/Ном худалдан авах зардал хэвлэл захиалгын төлбөрт хамаарч байгаагаас шалтгаалж үндсэн үйл ажиллагаанд хүндрэл гарч байгаа талаар соёлын салбарын байгууллагуудаас ирүүлж байгаа саналыг харгалзан номын санд ном худалдан авах зардлыг хэмнэлтэд хамааруулахгүй байхаар хуулийн төсөлд тусгав.

2/Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зохицуулалтаар төрийн ёслол хүндэтгэлийн болон төрийн байгууллагуудын шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгэхэд хүндрэл гарч байгааг харгалзан хуулийн 6.5.19 дэх заалтад холбогдох зохицуулалтыг нэмж тусгав.

3/ Иргэд, малчдад цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл хүргэх, отор нүүдлийн үед иргэдээ эргэх, цаг агаарын аюултай нөхцөл, байдлын үед газар дээр нь очиж шалгаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэргээр хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн үйлчилгээг анхан шатанд зохион байгуулж, хүргэх чиг үүргийг цаг хугацаа, орон зайг үл харгалзан үзүүлэх үүрэгтэй багийн Засаг дарга нарт орон нутагт дуудлагын автомашин, такси үйлчилгээ, түрээсийн автомашины үйлчилгээ олдоц хомс зэргийг харгалзан тухай чиг үүргийг хэрэгжүүлэхэд автомашин ашиглах талаарх зохицуулалтыг хуулийн 6.2 дахь хэсэгт нэмэхээр төсөлд тусгав.

3 дугаар зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн "ажлаас халах" гэснийг "Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх" гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн "2023" гэснийг "2025" гэж тус тус өөрчлөх.

Тайлбар:

1/ Хуулиар тогтоосон хориглосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд зөвхөн ажлаас халах хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг өөрчлөн Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгав.

3/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгахаар заасан. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд худалдан авах ажиллагааны оролцогчдын онцлог, нарийн мэргэшил шаардлагатай баримт бичгийг боловсруулах хугацаа зэрэг асуудлаас хамаарч хуулийн дээрх заалтад заасан хугацааг баримтлах боломжгүй нөхцөл үүсэхээр байгааг харгалзан хэрэгжих хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болгон өөрчлөх төслийг боловсруулав.

4 дүгээр зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “байж болно” гэснийг тус тус хасах

Тайлбар:

1/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй” гэж заасантай нийцүүлж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл буюу дүрэмт хувцастай холбоотой зохицуулалтаас “тусгай хувцас”-тай холбоотой хэсгийг хасахаар тусгав.

2/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т “сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр, шатахуун, дотоод албан томилолтын зардал”-ыг хориглосон нь зайлшгүй ажлын шаардлагаар хийх тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр биечлэн хийх бэлтгэл, галт зэвсэг, хэргийн газрын үзлэгийн сургалт, гал түймэртэй тэмцэх зэрэг сургалтуудыг цахимаар зохион байгуулах боломжгүй тул хүндрэл учирч байна. Иймд төрийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс зайлшгүй нүүр тулсан сургалт, уулзалт хийх, цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулах тодорхой шаардлага үүсээд байгааг харгалзан 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “байж болно” гэснийг хасах өөрчлөлтийг тусгав.

3.ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.1.6-19.1.11 дэх заалт нэмэх:

Тайлбар: Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн Л.Оюун-Эрдэнэ хүүхдийн төлөө байгууллагын үе үеийн 110 гаруй төлөөлөлтэй 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр уулзаж, санал хүсэлтийг нь сонссон. Уулзалтаас гарсан зөвлөмжийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиг үүргийг өөрчлөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгох болсонтой холбогдуулан тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан. Мөн дээрх өөрчлөлттэй уялдуулан залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон захиргааны байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах шаардлагатай болсон.

Тодруулбал, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлд буюу залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт нэмж тусгав. Мөн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг төрийн захиргааны төв байгууллагад шилжиж, ачаалал, ажил үүргийн хуваарилалт өөрчлөгдөж байгааг харгалзан залуучуудын хөгжлийг дэмжих зарим арга хэмжээ, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, тэдгээр төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар нэмж тусгав.

2 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн "20 дугаар зүйлийг "Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэг" гэж өөрчлөх:

Тайлбар: Өмнө дурдсанчлан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиг үүргийг өөрчлөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгохтой холбогдуулан тус агентлагийн залуучуудын хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх чиг үүргийг заасан 20 дугаар зүйл бүхэлдээ хүчингүй болгож энэхүү зүйлд Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүргийг шинээр тодорхойлов.

3 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг болон 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийн "Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас" гэснийг "Засгийн газрын холбогдох тусгай сангаас" гэж өөрчлөх:

Тайлбар:Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан Залуучуудын хөгжлийг дэмжих сан нь Засгийн газрын тусгай санд заасан зарим сангаас санхүүжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй давхацсан, холбогдох бусад сангуудаас санхүүжүүлэх арга хэмжээний хүрээнд болон бусад гарц, гаргалгааны үр дүнд хэрэгжилт хангагдаж байгааг харгалзан цаашид тус сантай хамаарах заалтыг хүчингүй болгох, сангаас санхүүжүүлэх арга хэмжээг залуучуудын

хөгжил, оролцоог дэмжих бусад санхүүжилт, төсөвлөлтөд тусгасантай уялдуулан өөрчлөв.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "төрийн захиргааны байгууллага" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага" гэж, 15.2 дахь хэсгийн "төв байгууллага баталж, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ." гэснийг "төв байгууллага батална." гэж өөрчлөх:

Тайлбар: Өмнө дурдсанчлан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиг үүргийг өөрчлөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгох болсонтой холбогдуулан залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дээрх чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамааруулан өөрчлөв.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлийн "19.1.6" дэх заалтын дугаарлалтыг "19.1.12" гэж өөрчлөх:

Тайлбар: Өмнө дурдсанчлан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиг үүргийг өөрчлөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгох болсонтой холбогдуулан залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны дээрх чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамааруулж 19 дүгээр зүйлд нэмж тусгасан тул зүйл, заалтын дугаарлалтыг өөрчлөв.

4 дүгээр зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, Тавдугаар бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцох:

Тайлбар: Өмнө дурдсанчлан, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан Залуучуудын хөгжлийг дэмжих сан нь Засгийн газрын тусгай санд заасан зарим сангаас санхүүжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй давхацсан, холбогдох бусад сангуудаас санхүүжүүлэх арга хэмжээний хүрээнд болон бусад гарц, гаргалгааны үр дүнд хэрэгжилт хангагдаж байгааг харгалзан цаашид тус сантай хамаарах заалтыг хүчингүй болгох, сангаас санхүүжүүлэх арга хэмжээг залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бусад санхүүжилт, төсөвлөлтөд тусгасантай уялдуулан тус сантай хамаарах дээрх заалт, бүлгийг тус тус хүчингүйд тооцохоор тусгав.

4.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 40.5-40.7 дахь хэсэг нэмэх:

"40.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний

хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болно.

40.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар энэ хуулийн 40.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилсон тохиолдолд байгууллага дэд даргатай байна.

40.7.Энэ хуулийн 40.5-д заасан байгууллагын дарга нь өөрийн хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамааран зарим эрхээ дэд даргад шилжүүлж болно.”

Тайлбар: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж, эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах зорилтууд туссан. 2022 оны байдлаар төрийн албанд нийт 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагаас 245 буюу 0.5 хувь нь удирдах албанд, 2811 буюу 57.7 хувь нь гүйцэтгэх албанд, 1808 буюу 37.1 хувь нь туслах албанд ажилладаг. Үүнээс төрийн улс төрийн албанд 71, төрийн захиргааны албан тушаалд 533, төрийн тусгай албан тушаалд 38, төрийн үйлчилгээний албан тушаалд 4222 хүн тус тус ажиллаж байна. Энэ нь төрийн захиргааны албан тушаал, удирдах албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж нөхцөл хангалтгүй байгааг илтгэх нэг үзүүлэлт юм.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт холбогдох нэмэлт оруулахын зэрэгцээ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болох бөгөөд энэ тохиолдолд байгууллага нь дэд даргатай байх зохицуулалтыг нэмж тусгасан. Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд биеийн зарим үйлдэл хязгаарлагдмал байдаг зарим чиг үүргийг дэд дарга хуваалцсанаар даргаар томилогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд бодит дэмжлэг болох юм.

5.ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 31-ний” гэж өөрчлөх.

Тайлбар: Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг сурталчлан таниулах, түншлэлээр хэрэгжүүлэх төслүүд, хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээ хийх, бэлэн байдлыг хангах, түншлэлийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх зэрэгт хугацаа

шаардлагатай байгааг харгалзан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тооцов.

6.ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.15 дахь хэсэг нэмэх.

“3.15. Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үйл ажиллагааны тодорхой чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээхтэй холбоотой ажил, үйлчилгээ худалдан авах, захиалгын дагуу тухайн чиглэлийн төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

Тайлбар: Шинжлэх ухааны салбарын тодорхой чиглэлээр мэргэжлийн түвшинд судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэдэг төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагууд нь төрийн байгууллага, төрийн өмчит компаниудаас зарласан ажил үйлчилгээний тендерт үндсэн гүйцэтгэгчээр сонгогдож чадахгүй байна. Үүний шалтгаан нь арилжааны банканд тендерийн барьцаа байршуулах данс нээх боломжгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.5-д зааснаар төсвийн хөрөнгөөр барьцаа гаргах боломжгүй, тендерт захиалагчаас тогтоосон санхүүгийн чадавхын үзүүлэлтийг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага хангах боломжгүй зэрэгтэй холбоотой байна. Энэхүү байдал нь дотооддоо хийх боломжтой шинжилгээ туршилтыг гадаадад өндөр үнээр хийлгэх, нөгөө талаас боловсон хүчний болон лабораторийн чадавхгүй дотоодын аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсний улмаас тендер үр дүнгүй болох зэрэг сөрөг үр дагавар гарч байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд холбогдох зохицуулалт хийх замаар монгол эрдэмтдийн чанартай судалгаанд суурилсан бодлого, шийдвэр хэрэгжүүлэх, өрсөлдөх чадвар бүхий технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой гэж үзэж байна.

7.ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн "9.10," гэснийг хасах.

Тайлбар: Нам орбитын хиймэл дагуулын сүлжээг харилцаа холбооны үйлчилгээнд ялангуяа өндөр хурдны өргөн зурвасын интернэтийн үйлчилгээнд ашиглаж газар зүйн байрлал харгалзахгүйгээр өндөр хурдны интернэтийн үйлчилгээг дэлхий даяар үзүүлж эхлээд байна. Энэ чиглэлээр Англи Улсын OneWeb, Канад Улсын Telesat, Америкийн нэгдсэн улсын Starlink, Project Kuiper зэрэг компаниуд үйл ажиллагаа эхлүүлэн дэлхийн хэмжээний корпорац болон өргөжиж, өөрсдийн үйлчилгээгээ дэлхийн 20 орчим оронд хүргэж байна. Манай улсын хувьд өргөн уудам газар нутагт тархан суурьшсан иргэдийнхээ харилцаа холбооны хэрэгцээг хангахын тулд Монгол Улсын өнцөг булан бүрд шилэн кабель татаж, харилцаа холбооны дэд бүтэц бий болгох нь өндөр өртөгтэй бөгөөд үр ашиггүй хөрөнгө оруулалт болж байна.

Иймд дээрх байршлуудад оршин суугаа иргэдийнхээ харилцаа холбоо, интернэтийн хэрэгцээг хангах, тоон хуваагдлыг бууруулах, онцгой байдал, бүх нийтийн үүрэгт үйлчилгээнд орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, өрсөлдөөнийг дэмжих чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Дээрх чиглэлийн дагуу нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглан интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд нь Монгол Улсад тус үйлчилгээг явуулахад Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.4.харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, 9.8.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах, 9.10.сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус тус авч үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэхээр байна.

Нөгөө талаар Харилцаа холбооны тухай хуулийн 12.4."Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид мөн зүйлийн 9.8, 9.13, 9.15-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй." гэж заасан байгаа нь нам орбитын хиймэл дагуул сүлжээ ашиглан интернэтийн үйлчилгээг үзүүлэх компанид Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10. сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон тохиолдолд 9.4, 9.8-д заасан бусад тусгай зөвшөөрлүүдийг олгох боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

Иймд тухайн 3 төрлийн тусгай зөвшөөрлийг нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглан интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид олгох боломжийг бүрдүүлэх, Монгол Улсад үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх, зах зээлийн өрсөлдөөн бий болгох, харилцаа холбооны дэд бүтэц хүрээгүй алслагдмал газарт амьдарч байгаа иргэдэд харилцаа холбооны, интернэтийн үйлчилгээ хүргэж, тоон хуваагдлыг бууруулах зорилгоор Харилцаа холбооны тухай хуулийн 12.4 дэх хэсгийн "9.10," гэснийг хасаж, өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

8.ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

1 дэх заалт.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт нэмэх:

"4/2023 оны 1-6 дугаар саруудад хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаагүй хүүхдэд 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэн уг хугацаанд ногдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох;

5/хэрэв эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн мөнгөн тэтгэмжээ Хүүхдийн төлөө санд шилжүүлэх хүсэлт гаргасан бол уг зохицуулалтыг холбогдох журамд тусгах."

Тайлбар: Эдийн засгийн нөхцөл байдал, төрийн хэмнэлтийн бодлогын хүрээнд хүүхдийн мөнгийг 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 91 хувьд олгохоор тооцож 2023 оны төсвийг баталсан. Энэ оны эхний 4 сарын байдлаар 1,143.4 мянган хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаж байна.

Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 2022 оны 1 дүгээр улиралд 3.9 хувиар агшаад байсан эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өссөн байна. Уул уурхайн салбарын сэргэлт, түүхий эдийн үнийн өсөлт, эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.3 их наяд төгрөгөөр давж биелэхээр байна. Эдийн засгийн эерэг өөрчлөлттэй уялдуулан Засгийн газраас энэ оны 1 дүгээр сараас хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд хүсэлт гаргасан тохиолдолд 7 дугаар сарын 1-ээс эхлэн нөхөж олгохоор тооцож шаардлагатай хөрөнгийг төсвийн тодотголд тусгасан.

Түүнчлэн, хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргаагүй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хэрэв хүүхдийн мөнгөн тэтгэмжээ Хүүхдийн төлөө санд шилжүүлэх хүсэлт гаргах бол шаардлагатай зохицуулалтыг холбогдох журамд тусгах талаар Засгийн газарт үүрэг өгөх заалтыг тусгав.

2 дахь заалт.Мөн тогтоолын 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэн Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд 100,000 (зуун мянга) төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг сар бүр олгосугай."

Тайлбар: Эдийн засгийн эерэг өөрчлөлттэй уялдуулан Засгийн газраас хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 91 хувиар хязгаарлахгүйгээр хүсэлт гаргасан

өрхийн хүүхэд бүрд олгохтой холбогдуулан одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа тогтоолын 1 дэх заалтыг өөрчлөн найруулахаар тусгасан.

9.ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

1 дэх заалт.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийн "17.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар" гэснийг "17.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар" гэж өөрчилсүгэй.

Тайлбар: Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн Л.Оюун-Эрдэнэ хүүхдийн төлөө байгууллагын үе үеийн төлөөлөлтэй 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөх хийсэн уулзалтаас гарсан зөвлөмжийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиг үүргийг өөрчлөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгох болсонтой холбогдуулан тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлтэй уялдуулж чиг үүргийн зохицуулалт хийх зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 он



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна. Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас тэтгэвэр авч буй ахмадуудын орлогын баталгааг сайжруулах шаардлага үүсээд байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийг ижил хувь, хэмжээгээр нэмэгдүүлж ирсэн нь тэтгэврийн зөрүү үүсэх үндсэн шалтгаан болсон. Энэхүү зөрүүг арилгах зорилгоор даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг өнөөгийн цалин хөлсний түвшинтэй жишиж ойртуулахад итгэлцүүрийн аргачлал ашиглаж байна. Уг итгэлцүүрийг Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор суурь оныг 2011 он болгон шинэчлэн баталснаас хойш өөрчлөгдөөгүй байгааг 2022 он болгож шинэчлэх шаардлагатай байна.

Түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого өсөх тул сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн батлах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс бонд, үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг тогтоохтой холбогдуулан шинээр зүйл нэмэх, мөн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн орлого, зарлагын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдаж тэтгэврийн зөрүүг арилгах цалингийн итгэлцүүрийг шинэчилснээр 164.6 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх бол итгэлцүүр ашиглан тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн зардлыг 10 хувиар нэмэгдүүлснээр 496.3 мянган хүний тэтгэврийн хэмжээ нэмэгдэх болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй байна.

--- оОо ---



ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын сангийн 2023 оны
төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн тухай*

Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10.0 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна. Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас тэтгэвэр авч буй ахмадуудын орлогын баталгааг сайжруулах шаардлага үүсээд байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийг ижил хувь, хэмжээгээр нэмэгдүүлж ирсэн нь тэтгэврийн зөрүү үүсэх үндсэн шалтгаан болсон. Энэхүү зөрүүг арилгах зорилгоор даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг өнөөгийн цалин хөлсний түвшинтэй жишиж ойртуулахад итгэлцүүрийн аргачлал ашиглаж байна. Уг итгэлцүүрийг Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор суурь оныг 2011 он болгон шинэчлэн баталснаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд энэ удаад 2022 оныг суурь он болгож шинэчлэн итгэлцүүрийг тогтоохоор боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдаж тэтгэврийн зөрүүг арилгах цалингийн итгэлцүүрийг шинэчилснээр 164.6 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх бол итгэлцүүр ашиглан тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн зардлыг 10.0 хувиар нэмэгдүүлэхэд 496.3 мянган хүний тэтгэврийн хэмжээ нэмэгдэх болно. Нөгөөтгээгүүр, төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого өсөх тул сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн батлах шаардлага үүсэж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд төсвийн алдагдал 1,425.7 тэрбум төгрөгөөр батлагдсан. Мөн Засгийн газрын өрийн эргэн төлөлт 2,760.2 тэрбум төгрөг, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ 4,185.9 тэрбум төгрөг байх төсөөлөлтэй байна. Үүнээс шалтгаалан Засгийн газрын дотоод үнэт цаасны гаргалтын хэмжээ 2023 онд 1,613.4 тэрбум төгрөг, Засгийн газрын 2023 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын зээллэгийн төлөвлөгөө”-нд туссан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтад Засгийн газрын үнэт цаасыг төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор гаргахаар тусгасан, мөн Засгийн газрын 2019 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын ерөнхий газар”-т үнэт цаас арилжаалж болохоор тусгасан байдаг.



Энэ хүрээнд Засгийн газар нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт “Хуримтлалын сангаас Засгийн газрын бонд,

Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батална.” гэж заасны дагуу 2023 онд “Нийгмийн даатгалын сан”-гийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргахаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл тус бүрээр:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – *Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмсүгэй:*

“6 дугаар зүйл. – Засгийн газар нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт “Хуримтлалын сангаас Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батална.” гэж заасны дагуу 2023 онд “Нийгмийн даатгалын сан”-гийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргахтай холбоотой оруулсан хуулийн нэмэлт.

2 ДУГААР ЗҮЙЛ – *Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:*

“1/3 дугаар зүйл: Дээр дурдсан үндэслэлийн хүрээнд Нийгмийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

2/5 дугаар зүйл: Дээр дурдсан үндэслэлийн хүрээнд Нийгмийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

3 ДУГААР ЗҮЙЛ – *Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн дугаарлалтыг “7 дугаар зүйл” гэж оорчилсүгэй:*

Хуулийн төсөлд оруулсан нэмэлт зүйлсийн нөлөөгөөр зүйлийн дугаарын өөрчлөлтийг оруулсан.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – *Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.*

Хуулийг мөрдөж эхлэх огноог тусгасан.

--- оОо ---



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын сангийн 2023 оны
төсвийн тухай хуульд нэмэлт, оорчлолт
оруулах тухай хуулийн төслийн тухай*

Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна. Энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас тэтгэвэр авч буй ахмадуудын орлогын баталгааг сайжруулах шаардлага үүсээд байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийг ижил хувь, хэмжээгээр нэмэгдүүлж ирсэн нь тэтгэврийн зөрүү үүсэх үндсэн шалтгаан болсон. Энэхүү зөрүүг арилгах зорилгоор даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг өнөөгийн цалин хөлсний түвшинтэй жишиж ойртуулахад итгэлцүүрийн аргачлал ашиглаж байна. Уг итгэлцүүрийг Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор суурь оныг 2011 он болгон шинэчлэн баталснаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд энэ удаад 2022 оныг суурь он болгож шинэчлэн итгэлцүүрийг тогтоохоор боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдаж тэтгэврийн зөрүүг арилгах цалингийн итгэлцүүрийг шинэчилснээр 164.6 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх бол итгэлцүүр ашиглан тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн зардлыг 10 хувиар нэмэгдүүлэхэд 496.3 мянган хүний тэтгэврийн хэмжээ нэмэгдэх болно. Нөгөөтээгүүр, төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого өсөх тул сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн батлах шаардлага үүсэж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд төсвийн алдагдал 1,425.7 тэрбум төгрөгөөр батлагдсан. Мөн Засгийн газрын өрийн эргэн төлөлт 2,760.2 тэрбум төгрөг, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ 4,185.9 тэрбум төгрөг байх төсөөлөлтэй байна. Үүнээс шалтгаалан Засгийн газрын дотоод үнэт цаасны гаргалтын хэмжээ 2023 онд 1,613.4 тэрбум төгрөг, Засгийн газрын 2023 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын зээллэгийн төлөвлөгөө”-нд туссан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтад Засгийн газрын үнэт цаасыг төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор гаргахаар тусгасан, мөн Засгийн газрын 2019 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын ерөнхий газар”-т үнэт цаас арилжаалж болохоор тусгасан байдаг.

Энэ хүрээнд Засгийн газар нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт “Хуримтлалын сангаас Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батална.” гэж заасны дагуу 2023 онд “Нийгмийн даатгалын сан”-гийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргахаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна.

--- оОо ---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмсүгэй:

“6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйл:

Нийгмийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4,175,192.1
	1.1 Ажил олгогчийн төлөх шимтгэл	1,807,829.2
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	1,401,337.8
	1.3 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	15,143.9
	1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	172.1
	1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	161,725.3
	1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,302.6
	1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,341.0
	1.8 Бусад орлого	8,973.1
	1.9 Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	774,367.1
	Нийт орлого	4,175,192.1

2/5 дугаар зүйл:

2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4,152,690.8
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	3,728,529.6
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	229,981.2
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	45,203.5
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	80,295.3
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	47,131.8
	1.6 Даатгуулагчид буцаан олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	21,549.4
Нийт зарлага		4,152,690.8

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн дугаарлалтыг "7 дугаар зүйл" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 он



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүтцийг 2022 оноос хойш үе шаттай шинэчлэх арга хэмжээг эхлүүлсэн бөгөөд энэ хүрээнд төрийн албан хаагчийн “14 сүлжээний 566 ялгаатай цалин”-г нэг шатлал бүхий “12 сүлжээний 109 суурь цалин”-тай болгож цэгцлээд байна. Энэхүү бодлогын арга хэмжээг үргэлжлүүлж “4 сүлжээний 42 суурь цалин”-тай болгохоор зорьж, төрийн албан тушаалын ангилал хоорондын цалингийн зөрүүг арилгах, цалингийн доод хэмжээг нэмэгдүүлэх, босоо болон хэвтээ удирдлагатай орон нутгийн бүх байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг ижил хувиар тооцож олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Уг арга хэмжээний нөлөөгөөр эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлсний зардал нэмэгдэж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгож буй тусламж, үйлчилгээний өртөг, тарифт өөрчлөлт оруулах шаардлага бий болж байна.

Түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлсний өсөлтөөс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого өсөхөөр байгаа тул эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн батлах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн орлого, зарлагын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэгдэх эх үүсвэрийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тарифт тохируулга хийх замаар үр ашигтай, оновчтой зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй байна.

--- оОо ---



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023
оны төсвийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн тухай*

Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүтцийг энгийн болгож хялбаршуулах зорилгоор 2022 оноос хойш үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Энэ бодлогын хүрээнд төрийн албан хаагчийн “14 сүлжээний 566 ялгаатай цалин”-г нэг шатлал бүхий “12 сүлжээний 109 суурь цалин”-тай болгож цэгцлээд байна.

Энэ бодлогын арга хэмжээг үргэлжлүүлж “4 сүлжээний 42 суурь цалин”-тай болгохоор зорьж, төрийн албан тушаалын ангилал хоорондын цалингийн зөрүүг арилгах, цалингийн доод хэмжээг нэмэгдүүлэх, босоо болон хэвтээ удирдлагатай орон нутгийн бүх байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг ижил хувиар тооцож олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.



Үүнтэй холбоотойгоор төсөвт байгууллагаас эрүүл мэндийн даатгалын санд төлөх шимтгэлийн орлогын хэмжээ нэмэгдэж, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тарифт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

--- оОо ---



ТАНИЛЦУУЛГА

*Эрүүл мэндийн даатгалын сангийн
2023 оны төсвийн тухай хуульд
оорчлолт оруулах тухай хуулийн
төслийн тухай*

Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүтцийг энгийн болгож хялбаршуулах зорилгоор 2022 оноос хойш үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Энэ бодлогын хүрээнд төрийн албан хаагчийн “14 сүлжээний 566 ялгаатай цалин”-г нэг шатлал бүхий “12 сүлжээний 109 суурь цалин”-тай болгож цэгцлээд байна.

Энэ бодлогын арга хэмжээг үргэлжлүүлж “4 сүлжээний 42 суурь цалин”-тай болгохоор зорьж, төрийн албан тушаалын ангилал хоорондын цалингийн зөрүүг арилгах, цалингийн доод хэмжээг нэмэгдүүлэх, босоо болон хэвтээ удирдлагатай орон нутгийн бүх байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг ижил хувиар тооцож олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.



Үүнтэй холбоотойгоор төсөвт байгууллагаас эрүүл мэндийн даатгалын санд төлөх шимтгэлийн орлогын хэмжээ нэмэгдэж, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тарифт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл тус бүрээр:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3 дугаар зүйл. Дээр дурдсан төрийн албан хаагчийн цалин хөлсний бүтцийг шинэчилж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх шинэчилсэн орлогын хэмжээг хүснэгтээр тусгасан.

5 дугаар зүйл. Дээр дурдсан төрийн албан хаагчийн цалин хөлсний бүтцийг шинэчилж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.

2 ДҮГЭЭР ЗҮЙЛ – Энэ хуулийг батлагдсан өдрөөс хойш дагаж мөрдөнө.

Хуулийг мөрдөж эхлэх огноог тусгасан.

--- оОо ---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйл:

"3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,603,474.6
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	636,407.1
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	252,060.1
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	687,445.3
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	27,562.1
	Нийт орлого	1,603,474.6

2/5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл. 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	1,603,474.6
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	688,550.5
	1.2 Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	773,938.6
	1.3 Эмийн санд олгох	89,982.5
	1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	11,003.1
	1.5 Эрсдэлийн сан	40,000.0
	Нийт зарлага	1,603,474.6

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг